



## СУХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2017 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үр нөлөөт байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**Ажлын гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа төлөвлөөгүй нь үр дүнд нөлөөлж байна.**



Баруун-Урт хот

2018 оны 6 дугаар сар

## АГУУЛГА

### Тайланг бэлтгэсэн:

#### Ажлын хэсэг

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор:

М.нарантуяа

Утас: 99029191

Ажлын хэсгийн ахлагч:

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Ажлын хэсгийн гишүүд:

Ахлах аудитор С.Ариунбаяр

Аудитор Б.Ариунзул

### 2018 оны 6 дугаар сар

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал дээрх дугаарын утсаар харилцана уу.

Хаяг:

Сүхбаатар аймаг Төрийн аудитын газар, Баруун-Урт сум 7-р баг АЗДТГ-ын 226 тоот

|  |     |
|--|-----|
| Аудитын зорил, хамрах хүрээ, арга зүй..... | 3-4 |
| Товчилсон үгийн тайлбар.....               | 5   |
| Хүснэгт, графикийн товъёог.....            | 5   |

**Бүлэг 1. Хөрөнгийн тооллого чанаргүй хийгдэж байгаатай холбоотой ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй, төсвийн зарцуулалт, бүртгэлд тавих удирдлагын хяналт хангалтгүй хэрэгжиж байна..... 6**

|   |       |
|---|-------|
| 1.1 Төсвийн төслийг хөтөлбөр арга хэмжээ бүрээр төлөвлөж байгаа боловч зарим зардлыг хууль эрх зүйн актанд үндэслэн боловсруулаагүй байна.....              | 6-7   |
| 1.2 Үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.....  | 7-8   |
| 1.3 Ажилчин албан хаагчидтай холбоотой үүссэн өрийг санхүүгийн тайланд толилуулаагүй байна.....   | 8-9   |
| 1.4 Зөвлөлийн бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тооллогын комисс хөрөнгийг үнэн зөв, чанартай, үр дүнтэй зохион байгуулаагүй байна. 9-10 |       |
| 1.5 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах боловсон хүчин дутмагаас тендерийг хуулийн хүрээнд явуулаагүй байна.....                                      | 10-11 |

**Бүлэг 2. Тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлийг бууруулах талаар бодитой ажил зохион байгуулаагүй, тасгийн эрхлэгч өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, эрүүл мэндийн боловсролыг иргэдэд хүргэж байгаа боловч үр дүнг тооцож хэвшээгүй байна..... 12**

|   |       |
|---|-------|
| 2.1 Нярайн эндэгдэл өмнөх оноос өссөн байна.....  | 12-15 |
| 2.2 Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын үр дүнг тооцож, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна.....   | 15-16 |
| 2.3 Томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлтийн үед тендерийн эмийн нийлүүлэлтийн хүрэлцээ хангамж дутагдалтай байна.....                                      | 16-18 |
| 2.4 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар В, С вирусын шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагджээ.....  | 18    |
| 2.5 Тасгуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх, гарсан үр дүн, сайн туршлагауудыг солилцох, үйл ажиллагааг идвэхижүүлэх шаардлагатай байна..... | 18-22 |
| 2.6 Тасгийн эрхлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.....  | 22-23 |

**Бүлэг 3. Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө байгаа боловч ихэнх ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж дундажаас доогуур, ёс зүйн зөрчил гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.....24**

|  |       |
|--|-------|
| 3.1 Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд хийгдэхээр төлөвлөгөөний биелэлтийг 90.2 хувиар хангаж, хэрэгжилтийг удирлагын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэжээ..... | 24-25 |
| 3.2 Зарим албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод ажлын чиг үүргийн давхардал гарч байна.....   | 25-26 |
| 3.3 Статистик мэдээ, тайланг батлагдсан маягын дагуу гаргаж хэвшжээ.....   | 26    |
| 3.4 Тайлант онд 14 иргэнийг түр ажлын байраар хангажээ.....  | 26-27 |
| 3.5 Нийт бүртгэгдсэн өргөдлийн 34.9 хувь буюу 72 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.....  | 27-28 |
| 3.6 Иргэдээс бичгээр болон амаар ирсэн санал гомдолд үндэслэн ёс зүйн алдаа гаргасан эмч, эмнэлгийн ажилтанд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажиллажээ.....  | 28-29 |

|                      |       |
|----------------------|-------|
| Аудитын дүгнэлт..... | 30    |
| Аудитын зөвлөмж..... | 30-31 |
| Хавсралтууд.....     | 31    |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

### 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийгдэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

### 2. Аудитын зорилт

Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

- I. Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр дүн
- II. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн
- III. Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны үр дүн

### 3. Аудитын хамрах хүрээ

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны санхүүгийн баримт материал, бодлогын баримт бичиг, Засгийн газар болон бусад эх үүсвэрээс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

### 4. Үндсэн мэдээлэл

Тайлант онд Аймгийн нэгдсэн эмнэлэг нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 2869.7 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 87.4 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 142.8 сая, Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих орлого 2202.4 сая, нийт 5302.3 сая төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 5244.3 сая төгрөгийн зардал гарчээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 297 ажилтан, албан хаагчидтайгаар эмнэлгийн 2 дахь шатлалын тусламж үйлчилгээг аймгийн иргэдэд үзүүлж байна. Байгууллагын хүний нөөцийн талаарх судалгаагаар нийт ажиллагсдын 23 хувийг их эмч, 47 хувийг сувилагч, тусгай мэргэжилтэн, 1.3 хувийг эмийн мэргэжилтэн, 29.8 хувийг эмнэлгийн бусад ажилтан эзэлж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэл хүнд сурталгүй үзүүлэх зорилгоор тасаг нэгжүүдийн нягтралыг тэнцвэржүүлж, зарим кабинет, нэгж хэсгийг холбогдох мэргэжлийн чиглэлээр нь харьяалуулж зохион байгуулалтыг хийж, зарим кабинет, нэгж хэсгийг холбогдох мэргэжлийн чиглэлээр тасаг нэгжүүдэд харьяалуулж үйл ажиллагааг тогтмолжуулжээ. Эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж 2017 онд 390.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ЭМЯ болон аймаг орон нутаг, бусад төсөл хөтөлбөрөөс олгогдсон байна.

Тайлант онд иргэдээс эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой 2, эмч ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой 2, эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой 14, ажилтнуудын нийгмийн

асуудалтай холбоотой 168, бусад 6, нийт 192 өргөдөл ирж, 190 өргөдлийг шийдвэрлэж хариу өгчээ. Нийт өргөдлийн 87.5 хувийг ажилтны нийгмийн асуудалтай холбоотой өргөдөл эзэлж байна.

## **6. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд**

Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай, НББОУС болон ЭМС-ын тушаал, ЗГ-ын тогтоол бусад хууль, тогтоомжуудыг шалгуур үзүүлэлт болгож ашиглав.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|              |   |
|--------------|---|
| АИТХ         | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  |
| АЗДТГ        | Аймгийн засаг даргын тамгын газар   |
| АНЭ          | Аймгийн нэгдсэн эмнэлэг   |
| АЗӨ          | Амьсгалын замын өвчлөл  |
| БГАУТХ       | Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж                               |
| БЗДХ         | Бэлгийн замаар дамжих халдвар   |
| ГССҮТ        | Гэмтэл согог судлалын үндэсний төв  |
| ДОХ          | Дархлалын олдмол хомсдол  |
| ЕМЭ          | Ерөнхий мэргэжлийн эмч  |
| ЗГ           | Засгийн газар   |
| ЗСС          | Зүрх судасны согог  |
| КТГ          | Компьютер томограф  |
| МЭЭ          | Мэдээгүйжүүлэлт эрчимт эмчилгээ   |
| НДШ          | Нийгмийн даатгалын шимтгэл  |
| НӨАТ         | Нэмэгдсэн өртгийн албан татвар  |
| НЭМ          | Нийгмийн эрүүл мэнд   |
| ӨМӨЗО        | Өвөр Монголын өөртөө засах орон   |
| СЗЭ          | Сэргээн засах эмчилгээ  |
| ТБОНӨХБАУХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| УНТЭ         | Улсын нэгдсэн төв эмнэлэг   |
| УИХ          | Улсын Их Хурал  |
| ШЯЗӨ         | Шээс ялгаруулах замын өвчлөл  |
| ХШЗӨ         | Хоол шингээх эрхтэний өвчлөл  |
| ХХК          | Хариуцлагатай хувьцаат компани  |
| ХБ           | Хөгжлийн бэрхшээл   |
| ЭБЭ          | Эх барих эмэгтэйчүүд  |
| ЭМ           | Эрүүл мэнд  |
| ЭМТ          | Эрүүл мэндийн төв   |
| ЭМГ          | Эрүүл мэндийн газар   |
| ЭХЭМҮТ       | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв  |
| ЭЭЗХ         | Эмийн эмчилгээг зохицуулах хороо  |
| ЭМЯ          | Эрүүл мэндийн яам   |
| ЭМС          | Эрүүл мэндийн сайд  |
| ЯТТ          | Яаралтай түргэн тусламж   |

## Хүснэгт, графикийн товъёог

|           |  |    |
|-----------|--|----|
| Хүснэгт 1 | Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулсан судалгаа                     | 6  |
| Хүснэгт 2 | Харилцах дансаар төвлөрсөн орлого  | 8  |
| График 1  | Амбулаторийн үзлэгээр илэрсэн гол тэргүүлэх өвчлөлийн 3 жилийн харьцуулалт | 12 |
| График 2  | Хэвтэн эмчлүүлэгчдийн тэргүүлэх өвчлөлийн 3 жилийн харьцуулалт             | 13 |
| Хүснэгт 3 | Сургалтын 3 жилийн харьцуулалт   | 16 |
| Хүснэгт 4 | ЯТТ-ийн 3 жилийн тоон үзүүлэлтийн харьцуулалт                              | 18 |
| Хүснэгт 5 | Дотрын тасгийн тэргүүлэх өвчлөлийн 3 жилийн харьцуулалт                    | 19 |
| График 3  | ЭХО үзлэгийн 2017 оны илрүүлэлт  | 21 |
| Хүснэгт 6 | 2017 онд ирсэн өргөдлийн шийдвэрлэлт                                       | 27 |
| График 4  | Иргэдээс бичгээр болон амаар гаргасан санал гомдлын 2 оны харьцуулалт      | 29 |

## Дэд зорилт-1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр дүн

1

## БҮЛЭГ 1

Хөрөнгийн тооллого чанаргүй хийгдэж байгаатай холбоотой ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй, төсвийн зарцуулалт, бүртгэлд тавих удирдлагын хяналт хангалтгүй хэрэгжиж байна.

**1.1 Төсвийн төслийг хөтөлбөр арга хэмжээ бүрээр төлөвлөж байгаа боловч зарим зардлыг хууль эрх зүйн актанд үндэслэн боловсруулаагүй байна.**

1.1.1 Аймгийн нэгдсэн эмнэлэгийн боловсруулсан төсвийн төслийг хөтөлбөр арга хэмжээ бүрээр тооцож гаргасан байна.

1.1.2 Төсвийн төслөөр тайлант онд 5,405.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Төсвийн төсөл, батлагдсан төсвийн харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулав. Хүснэгт №1

| Зардлын нэр                | мөнгөн дүн          |                     |                        | зөрүү               |                   |
|----------------------------|---------------------|---------------------|------------------------|---------------------|-------------------|
|                            | Төсвийн төслөөр     | анх батлагдсан      | Тодотголоор батлагдсан | төсөл               | анх батлагдсан    |
| Хог хаягдлын зардал        | 30,805.00           | 23,995.80           | 23,995.80              | -                   | 6,809.20          |
| Цалин                      | 2,842,239.30        | 2,557,912.00        | 2,686,372.30           | (128,460.30)        | 155,867.00        |
| НДШ                        | 312,646.30          | 281,370.20          | 295,500.90             | (14,130.70)         | 17,145.40         |
| Бичиг хэрэг                | 15,755.00           | 7,925.10            | 7,925.10               | -                   | 7,829.90          |
| Гэрэл цахилгаан            | 53,541.00           | 53,005.60           | 53,005.60              | -                   | 535.40            |
| Түлш халаалт               | 673,158.30          | 666,426.80          | 548,126.80             | 118,300.00          | 125,031.50        |
| Тээвэр шатахуун            | 83,164.60           | 92,333.00           | 92,333.00              | -                   | (9,168.40)        |
| Шуудан холбоо              | 3,323.80            | 2,961.40            | 2,961.40               | -                   | 362.40            |
| Цэвэр бохир ус             | 132,083.80          | 100,763.00          | 78,763.00              | 22,000.00           | 53,320.80         |
| Дотоод томилолт            | 20,599.10           | 23,393.10           | 23,393.10              | -                   | (2,794.00)        |
| Ном хэвлэл                 | 324.00              |                     |                        | -                   | 324.00            |
| Эд хогшил авах             | 13,540.20           | 6,297.30            | 9,797.30               | (3,500.00)          | 3,742.90          |
| Нормын хувцас              | 21,356.00           | 21,142.40           | 12,642.40              | 8,500.00            | 8,713.60          |
| Хоол                       | 180,180.00          | 143,590.60          | 143,590.60             | -                   | 36,589.40         |
| Эм                         | 972,654.70          | 836,575.80          | 986,575.80             | (150,000.00)        | (13,921.10)       |
| Урсгал засвар              | 24,447.40           | 21,731.00           | 21,731.00              | -                   | 2,716.40          |
| Нэг удаагийн тэтгэмж       | 15,605.00           |                     | 88,200.00              | (88,200.00)         | (72,595.00)       |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | 3,329.00            | 15,395.80           | 15,395.80              | -                   | (12,066.80)       |
| Хичээл үйлдвэрлэл          | 6,970.00            | 2,000.00            | 2,000.00               | -                   | 4,970.00          |
| Бага үнэтэй                |                     | 5,205.20            | 5,205.20               | -                   | (5,205.20)        |
| Сургалт                    |                     |                     |                        | -                   | -                 |
| <b>НИЙТ ДҮН</b>            | <b>5,405,722.50</b> | <b>4,862,024.10</b> | <b>5,097,515.10</b>    | <b>(235,491.00)</b> | <b>308,207.40</b> |



1.1.3 Эмнэлгийн ажилчдын үр дүнгийн урамшуулал олгох хувь хэмжээг 10-15 хувь байхаар ЗГ-ын 2012 оны 150 дугаар тогтоолд заасан бөгөөд төлөвлөхдөө дунджаар 14,4 хувиар төлөвлөж байна. Энэ нь эмнэлгийн ажилчдын мэргэжлийн чиг үүрэгтэй нь уялдуулан хувь хэмжээг төлөвлөөгүй, нийт дунд нь өсгөж төлөвлөж байгаа нь дээрх эрх зүйн акттай нийцээгүй байна. Мөн илүү цагийн тооцооллыг жилийн хуанли өдөр, ажилчдын хүрэлцээ хангамж, одоо байгаа нөөц, алсын дуудлагын давтамж, бодит гүйцэтгэл зэрэг тоон мэдээ, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй бөгөөд тухайн жилд олгогдох үр чадварын нэмэгдлийг Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын дагуу тооцож боловсруулаагүй байна.

1.1.4 Төсвийн төсөлд түлш халаалтын зардлыг 673.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламжийн нийт талбайн хэмжээ 36720 м<sup>3</sup>, одоо мөрдөгдөж байгаа НӨАТ шингэсэн нэгж талбайн өртөг 2090 төгрөгөөр тооцоход 537.2 сая төгрөг зарцуулах тооцоолол гарч байгаа бөгөөд зардлыг 136.0 сая төгрөгөөр илүү тооцоолж төлөвлөжээ.

1.1.5 Төсвийн төслийг хянаж батлахдаа 4862.0 сая төгрөгөөр буюу 543.7 сая төгрөгөөр хорогдуулан баталсан байна. Төсвийн нийт дүнгээр хорогдуулан баталсан боловч тээвэр шатахуун, дотоод томилолт, БГАҮТХ-ийг төсвийн төслөөс 2.8-12.1 сая төгрөгөөр нэмж хуваарилсан байна.

1.1.6 Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж төлөвлөгдөөгүй зардлыг нэмэгдүүлсэн байна. Энэ нь ЗГ-ын шийдвэрээр төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгоход 88.2 сая төгрөг, томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан эм, эмнэлэгийн хэрэгсэл худалдан авах зардлыг 150.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

1.1.7 Үйл ажиллагааны зардал хооронд шилжүүлэх хүсэлт гаргасаны дагуу түлш халаалт, цэвэр бохир ус, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 148.8 сая төгрөгийн зохицуулалт хийж цалин хөлс, НДШ, эд хогшил худалдан авах зардалд хуваарилсан байна.

1.1.8 Зарим нэр төрлийн зардлыг үнэн зөв бодит байдалд тулгуурлан төлөвлөөгүй, цалингийн сан хүрэлцэхгүй өр үүсч байгаа нь эмч, эмнэлэгийн ажилчдын үндсэн цалинг ЗГ-ын 2007 оны 354 тоот тогтоолоос өндөр тогтоож цалинжуулсан нь нөлөөлж байна.

## **1.2 Үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.**

1.2.1 ЭМС-ын 2016 оны А/228<sup>1</sup> тушаал, Эмнэлгийн даргын 2016 оны А/87<sup>2</sup> тушаалын дагуу 13 төрлийн төлбөртэй үйлчилгээ үзүүлж байна. Үйл ажиллагааны орлогыг 95.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 87.5 сая төгрөг төвлөрч 8.2 хувь буюу 7.8 сая төгрөгөөр тасарчээ.

1.2.2 Төлбөртэй үйлчилгээний орлого болох В,С вирус болон цусны омог тодорхойлох шинжилгээний орлого 2.2 сая, архины эмчилгээний орлого 1.5 сая, төлбөртэй өрөөний орлого 0.3 сая нийт 4.0 сая төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй зөрчил нь

<sup>1</sup> Төлбөртэй тусламж үйлчилгээний тариф, журам батлах тухай

<sup>2</sup> Төлбөртэй тусламж үйлчилгээний тариф, журам батлах тухай

Төсвийн тухай хуулийн 35.2<sup>3</sup>, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалыг 1<sup>4</sup> хавсралтын 2.6<sup>5</sup> дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

### 1.2.3 Харилцах дансаар төвлөрсөн орлогыг хүснэгтээр харуулав. Хүснэгт№2

| Орлогын төрөл               | сая.төг      |             |             |
|-----------------------------|--------------|-------------|-------------|
|                             | төлөвлөгөө   | гүйцэтгэл   | зөрүү       |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 53.3         | 53.3        | -           |
| Эмчийн үзлэг                | 7.9          | 7.9         | -           |
| Шинжилгээ оношлогоо         | 11.5         | 11.5        | -           |
| В,С шинжилгээ               | 7.7          | 5.5         | 2.2         |
| өмнөх оны үлдэгдэл          | 2.4          | 2.4         | -           |
| ХАЯТТасаг бусад             | 1.0          | 1           | -           |
| архины эмчилгээ             | 7.3          | 1.8         | 5.5         |
| төлбөрт өрөө                | 4.9          | 0.9         | 4.0         |
| аборт                       | 1.4          | 0.2         | 1.2         |
| амбулатори нүд каб          | 0.2          | 0.2         | -           |
| байгууллагын эмчийн үзлэг   | 7.8          | 2.3         | 5.5         |
| бусад                       | 0.3          | 0.3         | -           |
| <b>Дүн</b>                  | <b>105.7</b> | <b>87.3</b> | <b>18.4</b> |

Төсвийн харилцах дансанд төлбөртэй үйлчилгээний орлого 105.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 87.3 сая төгрөгийг Төсвийн дансанд төвлөрүүлж, гүйцэтгэлээр илэрхийлсэн байна. Харин 14.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 4.0 сая төгрөгийн үлдэгдлийг бүртгэлээр илэрхийлэлгүй, кассын няравт хадгалагдаж байна. Орлого тасарсан харагдаж байгаа боловч бодит гүйцэтгэлээр 112.5 сая төгрөг төвлөрсөн байна. Орлого бүрэн

төвлөрсөн байхад нэмэлт санхүүжилтийн дансанд орлогыг шилжүүлэн тасарсан байдлаар харагдуулж байгаа нь ажил хариуцсан албан тушаалтнуудын хариуцлагатай шууд холбоотой байна. Мөн орлого тасрах хэмжээгээр тухайн жилд зарцуулагдах урсгал зардлын хэмжээ багасах үр дагавартай юм.

### 1.3 Ажилчин албан хаагчидтай холбоотой үүссэн өрийг санхүүгийн тайланд толилуулаагүй байна.

1.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 5,302.5 сая төгрөгийн орлого санхүүжилттэй, үйл ажиллагааны зардалд 5,244.3 сая, хөрөнгө худалдан авахад 47.6 сая төгрөг зарцуулж 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

1.3.2 Үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардлын 51.3 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, 13.0 хувийг байр ашиглалтын зардал, 19.3 хувийн эм, эмнэлэгийн хэрэгсэл худалдан авахад, 16.4 хувийг бусад нэр төрлийн зардалд зарцуулжээ.

1.3.3 Төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд аудитаар илэрлээ. Үүнд:

- *Алсын дуудлага, яаралтай түргэн тусламжийн хүргэлт үйлчилгээнд зарцуулсан шатах тослох материалаас 2.6 сая төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдоогүй тул албан шаардлага хүргүүлээ.*

<sup>3</sup> Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн **орлого** болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.

<sup>4</sup> Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам

<sup>5</sup> Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касс бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана



- Засгийн газрын шийдвэрээр олгогдсон үр дүнгийн урамшуулалт мөнгөн тэтгэмжийг сахилгын шийтгэлтэй 11 албан тушаалтанд 2.9 сая төгрөг олгосонд төлбөрийн акт тогтоолоо.
- Санхүүгийн тайланд өмнөх оны зардлын гүйцэтгэл 4.6 сая төгрөгийг өр төлбөрөөр тайлагнаагүй байна. Ажилчин албан хаагчидтай холбоотой өглөг үүссэн нь зарим эмч, эмнэлэгийн ажилчдын үндсэн цалин 3Г-ын 2007 оны 354, 2014 оны 75, 208 тогтоолын дагуу цалинжуулаагүй, цалин хэт өндөр тогтоож, батлагдсан төсвийг арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Дээрх алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41.2.2<sup>6</sup>, 41.2.3<sup>7</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4<sup>8</sup>, 13.7<sup>9</sup>, Төрийн албаны тухай хуулийн 26.6<sup>10</sup>, Засгийн газрын 2017 оны 52 тоот хурлын тэмдэглэлийг зөрчсөн байна.

#### 1.4 Зөвлөлийн бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тооллогын комисс хөрөнгийг үнэн зөв, чанартай, үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

1.4.1 Нэгдсэн эмнэлэг нь төсвийн хөрөнгөөр 47.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч, дээд шатны байгууллага болон бусад эх үүсвэрээр /хандив тусламж/ 511.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй ирж, данс бүртгэлд тусгажээ. Тайлант онд аймгийн ИТХ-ын шийдвэртэй 108.2 сая төгрөгийн өртөгтэй авто тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

1.4.3 Хөрөнгийн тооллогын чанар, үр дүн, данс бүртгэлийн хөтлөлттэй холбоотой дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- ✓ Ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглагдах боломжгүй, дансанд бүртгэлтэй боловч биетээр байхгүй 13.8 сая төгрөгийн өртөгтэй 354 нэр төрлийн тавилга, эд хогшил, 57.6 сая төгрөгийн өртөгтэй 276 нэр төрлийн эмнэлэгийн тоног төхөөрөмжийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй байна.
- ✓ Япон улсын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжаар 2014 онд нийлүүлэгдсэн 156.0 сая төгрөгийн өртөгтэй авто тээврийн хэрэгслийг данс бүртгэлд тусгаагүй.
- ✓ Тасаг нэгжүүдэд хандив тусламжаар болон албан хаагчдын өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй байна.

1.4.4 Байгууллагын өмч хамгаалах комисс болон тооллогын комиссын гишүүд хууль эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийн жагсаалт гарган хэлэлцэж дүгнэлт гаргаагүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тогтмол хяналт тавьж шийдвэр гаргаагүйгээс,

<sup>6</sup> Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

<sup>7</sup> Төсвийн гүйцэтгэлийг хууль, тогтоомжийн дагуу гаргаж тайлагнах

<sup>8</sup> үнэн зөв байх;

<sup>9</sup> Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

<sup>10</sup> Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлтэйд тооцно.

хөрөнгийг данс бүртгэлээс хасах, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах зэрэг зөрчил дутагдал гарахад нөлөөлж байна. Тооллогын комиссууд хөрөнгийн тооллогыг балансын дүн, тоо ширхэгээр нэг бүрчлэн бүртгэж тоолдоггүй, чанартай зохион байгуулдаггүйгээс дээрх зөрчил гарчээ.

1.4.5 Дээрх алдаа зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.3<sup>11</sup>, 72.4.1<sup>12</sup>, 72.4.5<sup>13</sup>, 73.3<sup>14</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5<sup>15</sup> дахь заалтуудыг зөрчсөн учир цаашид зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

## 1.5 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах боловсон хүчин дутмагаас тендерийг хуулийн хүрээнд явуулаагүй байна.

1.5.1 Нэгдсэн эмнэлэгийн эм, эмнэлгийн хэрэгсэл тендер сонгон шалгаруулалтаар нийлүүлэгдэж байна. Хэдийгээр сонгон шалгаруулалтаар эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдэж байгаа боловч аймгийн хэмжээнд шаардлагатай эмийн тендерийг ЭМГ-т нэгтгэн зарлаж, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах эрхийг нэгдсэн эмнэлэгт олгосон байна.

1.5.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шүдний тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нийлүүлэх тендерийн эрх шилжүүлсний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

1.5.3 Харин тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулахдаа эмнэлгийн даргын А/75 тоот тушаалаар ЭМГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтэн, АЗДТГ-ын мэргэжилтэн, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн нарыг томилсон байна. Үнэлгээний хороог ийм бүтэцтэй томилсон нь нэгдсэн эмнэлэгт ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.3.1<sup>16</sup>, 47.6<sup>17</sup>-д заасан шаардлагад нийцэх албан тушаалтан байхгүй, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах албан хаагч хомсдолтой зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Иймд зарим албан хаагчийг худалдан авах ажиллагааны сургалтанд хамруулж, тендер сонгон шалгаруулалтын мэдлэг олгох, туршлага судлуулах шаардлагатай байна.

<sup>11</sup> засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;

<sup>12</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>13</sup> эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих.

<sup>14</sup> нэр төрлийн материал үнэ бүхий зүйлийн дутагдлыг бусад үнэ бүхий зүйлийн илүүдлээр нэг эд хариуцагчаас гарсан дутагдлыг нөгөө эд хариуцагч дээр гарсан илүүдлээр, хоёр өөр хугацаанд гарсан нэг төрлийн адил үнэтэй зүйлийн дутагдлыг илүүдлээр хаахыг хориглоно. Харин тооллогоор илэрсэн илүүдлийг зохих дансанд орлого болгож илүүдэл гарсан шалтгааныг тогтооно;

<sup>15</sup> Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

<sup>16</sup> худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх;

<sup>17</sup> Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

1.5.4 Үнэлгээний хороонд шүдний мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтанг томилоогүйгээс техникийн тодорхойлолтыг гаргахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.1<sup>18</sup>, 11.1.2<sup>19</sup>-т заасны дагуу боловсруулаагүй байна.

1.5.5 Уг тоног төхөөрөмжийг гэрээ байгуулсан өдрөөс 7-10 хоногийн дотор нийлүүлэхээр заасан боловч гүйцэтгэгч Оюудент ХХК нь тоног төхөөрөмжийг хугацаандаа нийлүүлээгүй байна. Гэрээний үүргээ биелүүлээгүй нь захиалагч байгууллагатай холбоотой бөгөөд тоног төхөөрөмжийг суурилуулах өрөөнд урсгал засвар хийгдэж дуусаагүйгээс шалтгаалжээ.

1.5.6 Мөн гэрээнд гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг нийлүүлж хүлээлгэн өгсний дараа санхүүжилтийг олгохоор заасан боловч барааг нийлүүлэхээс 5 хоногийн өмнө гүйцэтгэгчид санхүүжилтийг олгосон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44.4<sup>20</sup> заалтыг зөрчсөн байна.

1.5.7 Төсвийн байгууллага жилийн дүнгээр батлагдсан төсвийг багцлан авч үзэж, төсвийг үр ашигтай зарцуулах тогтолцоог бий болгох нь Төсвийн тухай хууль тогтоомжуудтай уялдах юм. Тухайлбал Тус байгууллагын хувьд жилийн дүнгээр худалдан авч байгаа хоол хүнс, тээвэр шатахууныг багцлан тендер сонгон шалгаруулалт хийж, бэлтгэн нийлүүлэгчийг тодорхойлох нь төсвийн худалдан авалтад үр ашиг бий болох боломжтой юм. Төсвийг үр ашигтай байлгах нь удирдлагаас шууд шалтгаалах зүйл учир төсвийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй юм. Бүртгэлээр болон төсвийн зарцуулалттай холбогдон гарч байгаа зөрчил, дутагдал нь байгууллагын удирдлагатай шууд холбогддог гэдгийг Төсвийн тухай хууль болон холбогдох заавар журмаар заасныг анхааралдаа авах шаардлагатай байна.

Дэд зорилтуудын хүрээнд гарсан зөрчил дутагдал нь үе үеийн удирдлагын санхүүгийн дотоод хяналт сул, санхүүгийн дотоод хяналт явуулах мэргэжлийн боловсон хүчин хангалтгүйтэй холбоотой гэж үзэж байна.

<sup>18</sup> тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн үзүүлэлтээр тодорхойлох;

<sup>19</sup> .Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх, ийм стандарт байхгүй тохиолдолд үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх;

<sup>20</sup> Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

Дэд зорилт-2 : Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн

2


**БҮЛЭГ 2**

*Тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлийг бууруулах талаар бодитой ажил зохион байгуулаагүй, тасгийн эрхлэгч өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, эрүүл мэндийн боловсролыг иргэдэд хүргэж байгаа боловч үр дүнг тооцож хэвшээгүй байна.*

**2.1 Нярайн эндэгдэл өмнөх оноос өссөн байна.**

2.1.1 Нэгдсэн эмнэлгийн хэмжээнд гаргасан статистик мэдээнээс давхардсан тоогоор нийт 107.6 мянган иргэн үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад үзлэгийн тоо 1.3 хувиар өссөн байна. Үзлэгийн тоо өссөн нь тайлант онд явуулын амбулаторийн үзлэгт хамруулах сумдын тоог нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

Өмнөх жил болон тухайн жилүүдийн статистик тоо мэдээ, амбулаторийн үзлэг оношлогоонд тулгуурлан тэргүүлэх чиглэлийн өвчлөлд судалгаа хийхэд дараах үр дүн гарсан байна График№1 /10000 хүн амд ногдох/



2.1.2 Тайлант онд хоол шингээх эрхтэний өвчлөл, амьсгалын тогтолцооны эмгэг өмнөх оноос 2.8-178.6 промелиар өссөн байна. Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл нэмэгдэж байгаа нь иргэдийн амьдралын буруу хэвшил, хэт таргалалт, архи тамхины зохисгүй хэрэглээ зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Мөн амьсгалын замын өвчлөл нэмэгддэг нь томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлт ихэссэн, иргэд томуугийн дэгдэлтийн үед эмчийн зааваргүй дур мэдэн эм, антибиотик хэрэглэдэг, өвчин хүндэрсэн хойно эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа нь нөлөөлж


байна. Тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлийн шалтгаан, нөхцлийг тодорхойлсон боловч ямар чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх, өвчлөлийг хэрхэн бууруулах талаар төлөвлөгөөнд тодорхой ажлууд төлөвлөгдөөгүй байна.

2.1.3 Харин мэдрэлийн кабинетийн эмч мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчлөлийг 5 жилээр харьцуулсан судалгаа гаргасан байна. Судалгаанд дүн шинжилгээ хийхэд нийт өвчлөлийн 31.2 хувийг нурууны өвчлөл эзэлж байгаа бөгөөд иргэдийн амьдралын буруу хэвшил, хөдөлгөөний хомсдол зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Иймд нийгмийн

боловсрол олгох үйлчилгээг тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлтэй уялдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэдэд чанар, хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

2.1.4 Халдварт бус өвчлөл буурахгүй байгаа нь иргэдийн хөдөлгөөний дутагдал, архи тамхины хэрэглээ, амьдралын буруу хэвшил мэдрэлийн тогтолцоо, хоол шингээх эрхтний өвчлөл үүсэхэд нөлөөлж байна. Харин нүдний эмчийн гаргасан судалгаагаар хүүхэд, залуучуудын дунд компьютер, гар утасны хэрэглээ болон цахим орчинд ихэнх цагийг зарцуулж байгаа нь арьс харшил, нүд, түүний дайврын өвчлөл нэмэгдэхэд нөлөөлжээ.

Хэвтэн эмчлүүлэгчдийн тэргүүлэх чиглэлийн өвчлөлийг гурван жилээр харьцуулж дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарлаа. График №2 /10000 хүн амд ногдох/



2.1.5 Тайлант онд хэвтэн эмчлүүлэгчдийн тэргүүлэх зэргийн өвчлөл өмнөх оноос 1.3-18.6 промелиар буурч байгаа хэдий ч эмнэлгийн удирдлага, нарийн мэргэжлийн эмч нар статистик тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж учир шалтгааныг тооцож дүгнээгүй байна.

2.1.6 Статистик мэдээнээс үзэхэд эмнэлгийн нас баралт 35 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 7 тохиолдол буюу 25 хувиар нэмэгдсэн байна.

2.1.7 Хэвтэн эмчлүүлэгч болон амбулаторийн үзлэгээр илэрсэн өвчлөлийн тэргүүлэх зэрэгт хоол шингээх эрхтэний өвчлөл, амьсгалын тогтолцооны эмгэг, мэдрэлийн тогтолцооны эмгэг зэрэг өвчлөл тогтмол дээгүүр эрэмбэлэгдэж байна.

2.1.8 Мөн амбулаторийн үзлэгээр тэргүүлэх зэргийн өвчлөлд нүд ба түүний дайврын өвчнүүд эрэмбэлэгдэж байгаа бөгөөд энэ нь тайлант онд нүдээр халдварлах томуугийн дэгдэлт ихэссэнтэй холбоотой байна.

2.1.9 Эмнэлгийн комиссын шийдвэрээр гурав дахь шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах, хагалгаа хийлгэх, хүндрэлтэй төрөх нөхөн үржихүйн насны эхчүүдийг хүргэж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлжээ. Гэсэн хэдий ч гурав дахь шатлалын эмнэлэгт хүргэгдсэн өвчтөний бүртгэлгүй, тухайн өвчтөний мэдээлэл хангалтгүй байна.

2.1.10 Нэгдсэн эмнэлгийн удирдагууд тэргүүлэх чиглэлийн өвчлөлийн өсч буурч байгаа шалтгаан, нөхцөл байдлыг судлах, түүнийг бууруулах талаар тодорхой ажлуудыг төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх, үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах нь зохистой байна. Мөн хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний судалгаа, шинжилгээг тогтмол хийж хэвших, эмч нар зөвхөн эмчлээд гаргах бус өвчний суурь ужгийг тогтоох, түүнд тохирсон үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгуулж байх нь байгууллагын үр нөлөөг дээшлүүлэх боломжтой болох юм.

2.1.11 Аймгийн нэгдсэн эмнэлэгт нялхасын эндэгдэл 12 бүртгэгдэж өмнөх онтой харьцуулж үзэхэд 1 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн нялхасын эндэгдлийн 9 тохиолдол буюу 75 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна.

Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор тусгай төлөвлөгөө гарган батлуулж ажилласан байна. Тухайлбал:

- *ЭХЭМҮТ-өөс мэргэшсэн эмч солилцон ажиллуулах, ажлын байрны сургалт хийж, ажлын байранд үнэлгээ зөвлөмж гаргуулсан байна.*
- *Жирэмсэн эхчүүдийн хяналтыг сайжруулах эмнэлгийн даргын 2017 оны А/52 тоот тушаалаар “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журмуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналтын журам” боловсруулж баталсан.*
- *Эх барихын болон хүүхдийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах, амь тэнсэн үед үзүүлэх яаралтай тусламжийн мэдлэг, ур чадварыг бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулжээ.*

2.1.12 Нярайн эндэгдлийн нийт тохиолдолын 44 хувь буюу 4 тохиолдол хэт дутуу, 2 тохиолдол буюу 22 хувийг төрөлхийн гажигтай, 3 тохиолдол буюу 34 хувийг сэргийлж болох эндэгдэл эзэлж байна. Тайлант онд 1 сараас 1 настай хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдсэнийг эмгэг судлалын дүгнэлтээр 2 тохиолдлыг хавсарсан буюу удамшлын эмгэгтэй гэж үзжээ. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос буурсан байна. Дээрх нэг тохиолдол нь тархины хавдарын улмаас эндсэн бөгөөд эмгэг судлалын дүгнэлтээр онош тохирсон байна.

2.1.15 Тайлант онд 1 эх эндсэн тохиолдол бүртгэгдэж Эмгэг судлалын үндэсний төвөөс зөвлөх эмч урьж дүгнэлт гаргуулсан байна. Дээрх гарсан дүгнэлтээр эхэд үндсэн оношийн зөрүү гарсан тул хариуцлага алдсан эмч, эмнэлгийн ажилчдад сахилгын хариуцлага тооцсон байна.

2.1.16 Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор томуугийн дэгдэлтийн үед шуурхай ажлын төлөвлөгөө гарган, нэмэлт тасаг ажиллуулсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн болон төрөх тасагт тоног төхөөрөмж нэмэгдүүлсэн нь тодорхой үр дүнд хүрч 1-5 хүртэлх хүүхдийн эндэгдэл тодорхой хэмжээнд буурсан үзүүлэлттэй гарсан байна.

2.1.17 Эх хүүхдийн эндэгдэл гарсан тохиолдол бүрт комисс ажиллаж, хийгдсэн эмчилгээ, гаргасан үр дагаврын талаар тухай бүр хуралдаж дүгнэлт гаргасны дагуу ажил сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна.

2.1.18 Мөн нялхасын эндэгдлийг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган эмч, эмнэлгийн ажилчдыг сурган дадлагажуулах, иргэдэд сургалт сурталчилгааг хүргэж байгаа боловч нялхасын эндэгдэл буураагүй бөгөөд цаашид энэ чиглэлээр илүү анхаарч ажиллах нь зүйтэй юм.

2.1.19 Мөн төрөх эмэгтэйчүүдийн тасагт нарийн мэргэжлийн 5 эмч ажиллаж байгаа нь дутагдалтай байдаг бөгөөд зарим тохиолдолд алсын дуудлагад явсан, жижүүрт



хоносон эмчийг яаралтай болон төлөвлөгөөт хагалгаанд оруулж байгаа нь эх эндэх, эмч алдаа дутагдал гаргах эрсдэлтэй байна. Энэ тохиолдолд эмч нарын ажил үүргийг оновчтой зохион байгуулах, нарийн мэргэжлийн эмчийн орон тоог нэмэгдүүлэх саналыг яам, шат шатны дээд байгууллагуудад санал оруулах, төсөв хөрөнгөтэй нь холбогдуулан авч үзэх шаардлага үүсчээ.

2.1.20 Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээ үйлчилгээнд MNS4621:2008 стандартыг баримтлан иргэдэд эмчилгээ үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

2.1.21 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүнд өвчтнүүдэд яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагын шатлал хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор ЭХЭМҮТ, ГССҮТөв, УНТЭ, УГТЭмнэлэг, сумын ЭМТөвүүдтэй хамтран ажиллаж байна. 2017 оны 11 сарын байдлаар 82 удаагийн хүргэлтээр жирэмсэн 34, төрсний дараах 4, нярай 5, 0-1 нас хүртэлх хүүхэд 8, 1 наснаас дээш хүүхэд 10, гэмтэл түлэгдэл 4, тархины гэмтэл 4, могойд хатгуулсан 2, бусад гэмтэл-5, дотор зүрх судас 12, цусны эмгэг 3, элэг 1, бөөр буглаа 4, мэдрэл 6, сэтгэц 1, хавдар 2 тус тус шилжүүлж тусламжийг үзүүлж амь насыг аварсан байна. Орон нутагт төрөлжсөн мэргэжлийн эмнэлгээс нийт 9 удаа алсын түргэн тусламжаар эмч дуудан 14 хүнд тусламж авсны 9 тохиолдолд мэс засал хийгдэн тухайн хүмүүсийн амь нас аварсан байна.

2.1.22 Эмнэлгийн удирдлага, эмчилгээ эрхэлсэн орлогч болон тасаг нэгжийн нарийн мэргэжлийн эмч бүртгэгдсэн өвчлөлд судалгаа, дүн шинжилгээг хангалтгүй хийж байгаагаас тэргүүлэх зэрэглэлийн өвчлөл болон нярайн эндэгдэл өмнөх оноос өссөн, эхийн эндэгдэл өмнөх оны түвшинд байна .

## **2.2 Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын үр дүнг тооцож, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна.**

2.2.1 АНЭ-ийн Сувилахуйн алба нь 2017 онд иргэд үйлчлүүлэгчдэд болон эмч, эмнэлгийн ажилчдад хүргэх сургалтын төлөвлөгөөг сувилахуйн сургалт, сувилахуйн чанар сайжруулах сургалт, хэвтэн эмчлүүлэгчдийн сургалт гэсэн чиглэлээр боловсруулан батлуулжээ.

2.2.2 Иргэд, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгосон байдлыг тасаг нэгжийн тоон мэдээнээс авч үзэхэд нийт 1547 төрөл сэдвээр давхардсан тоогоор 203.7 мянган иргэнд 18.9 мянган удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна. Хэдийгээр сургалтын төрөл, хамрагдсан хүний тоо нэмэгдэж байгаа ч сургалтын чанар, үр дүнг тооцож цаашид хэрэгжүүлэх сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна.

2.2.3 Олон нийт мэдээллийн хэрэгслээр эмнэлгийн үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор МҮОНТ, TV9, UBS, MN25, TV5 телевизээр мэдээ сурвалжлага , орон нутгийн SB, BBS телевизээр 3, өдөр тутмын сонин хэвлэлээр 5 удаагийн сургалт сурталчилгааг иргэдэд хүргэжээ.

АНЭ-ээс хийгдсэн сургалтыг өмнөх онуудтай харьцуулсаныг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №3

| Үйл ажиллагаа        | 2015  | 2016  | 2017   |
|----------------------|-------|-------|--------|
| Төрөл                | 88    | 1983  | 1547   |
| Удаа                 | 6796  | 6050  | 18884  |
| Хамрагдсан хүний тоо | 70451 | 68762 | 203741 |

2.2.4 Эрүүл мэндийн боловсрол олгох төрлийн тоо огцом нэмэгдсэн нь ЭМЯ, ЭМГ-т хүргэдэг сургалт сурталчилгааны маягт өөрчлөгдсөн, тасаг нэгжүүд нэгдсэн ойлголтгүйгээс сургалтын төрлийг буруу мэдээллэх

хандлагатай байна. Иймээс тасаг нэгжүүдийн ахлах сувилагч нарт сургалтын төрөл, нэгж сургалтын сэдвийн талаар нэгдсэн ойлголтонд хүргэх цаашид мөрдлөг болгон ажиллах талаар зөвлөлөө.

2.2.5 Мөн 2017 оныг Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласантай холбоотойгоор иргэдэд хүргэх эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын давтамжийг нэмэгдүүлсэн, мөн Эрүүл Монгол хүн хөтөлбөр, өсвөр үеийн 15-19 насны хүүхдийн дунд ДОХ, БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэг зэрэг ажлыг зохион байгуулснаар хамрагдсан хүний тоо нэмэгдсэн байна.

### 2.3 Томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлтийн үед тендерийн эмийн нийлүүлэлтийн хүрэлцээ хангамж дутагдалтай байна.

2.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлгийн ЭЭЗХорооны болон антибиотикийн салбар зөвлөл нь 2017 онд хийх ажлын төлөвлөгөө гарган ерөнхий эмчээр батлуулан ажиллажээ.

2.3.2 Эм, эмнэлгийн хэрэгслийг тендер сонгон шалгаруулалтаар нийлүүлэгдэж байгаа боловч зарим тохиолдолд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг аймгийн эмийн худалдаа эрхэлдэг газруудаас худалдан авч тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх ажлыг зохион байгуулж ажиллажээ.

2.3.2 ЭМС-ын 2009 оны 388<sup>21</sup> тушаалаар батлагдсан журмын дагуу амин чухал 50 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгслийн нөөцөөр бүрэн хангагджээ.

2.3.4 Эмийн чанар аюулгүй байдлын хувьд эмнэлэгт нийлүүлэгдэж байгаа эм эмнэлгийн хэрэгсэл нь чанарын баталгаатай, улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан эсэхийг ЭЭЗХороо болон Чанарын албанаас мониторинг хийгддэг байна.

2.3.5 Тендерээр ирсэн эм эмнэлгийн хэрэгсэлүүд нь тээвэрлэлтийн явцад болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан эвдэрч, хагарч гэмтэж ирэх тохиолдолд гарсан байна. Тухайлбал 2017 онд шаардлага хангахгүй болон тээвэрлэлтийн явцад гарсан асуудлуудын талаар холбогдох компаниудад танилцуулан, эм хэрэгсэлүүдийг татсан бүтээгдэхүүний хуудсаар буцаах, тендерийг хугацаанд нь нийлүүлэхгүй, гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа компаниудын талаар аймгийн ЭМГ-т албан бичгээр мэдэгджээ. Үүнд “Мөнхийн тун” ХХК нь чанарын шаардлага хангахгүй байсан уян зүү, мэс заслын викрил утас, аюулгүй хайрцгийн талаар албан бичгийг явуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

2.3.6 Нэгдсэн эмнэлэг нь ЭМС-ын 2014 оны 336 тоот тушаал<sup>22</sup>-аар батлагдсан журмын дагуу мэдээ гаргахад: нийт хэвтэн эмчлүүлсэн өвчтөн 7765, эмчилгээнд хэрэглэсэн

<sup>21</sup> Амин чухал эм эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам

<sup>22</sup> Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах журам

эмийн тоо 650193, нийт хэрэглэсэн эмэнд эзлэх антибиотик эмийн тоо 120570, тарилгын эмийн тоо 420130, хэрэглэсэн эмэнд ЗШЭ-ийн эзлэх хувь 90.1 хувь, илэрсэн гаж нөлөөний тоо 10, эмчилгээ оношлогооны удирдамжийн дагуу эмчилгээнд хийгдсэн эмийн эзлэх хувь 93.2 хувь, нэг өвчтөнд хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн эмийн дундаж тоо 6 гарсан үзүүлэлттэй байна. Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд бүлгүүдийн эзлэх хувь Пенциллиний бүлэг 12.1 хувь, Цифалоспорины бүлэг 75 хувь, фторхинолины бүлэг 6.3 хувь, Аминоглинозидууд бүлэг 6.2 хувь, макролидын бүлэг 0.3 хувийг тус тус эзэлсэн байна.

2.3.7 Эмийн сан болон тасаг нэгжүүдэд дотоод хяналтыг клиник эм зүйчтэй хамтран 8-н тасагт 12 удаа хийж, тасгийн хяналтын хуудсаар дүгнэж, хяналтын талаар зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтийг хянаж ажиллажээ. Эмийн гаж нөлөөг үнэлэмжээр нь илэрхий, үнэмшилтэй, байж болох, үгүй гэж 4 ангилжээ. ЭМС-ын 415<sup>23</sup> дугаар тушаалын дагуу эмийн гаж нөлөө аюулгүй байдлыг тасаг бүрээс авахад байж болох-9, үнэмшилтэй-1 тохиолдол гарч ЭЭЗХ-ны гишүүд үнэлгээ хийж, эмийн санд бүртгэсэн байна. Бүртгэлд орсон эмийн гаж нөлөөний 10 тохиолдлыг тасгаар авч үзвэл: Хүүхдийн тасаг-5, Мэс засал-2, Төрөх-2, Мэдрэлийн тасаг-1 тохиолдол тус тус илэрчээ. Эмийн гаж нөлөөг насжилтаар нь үзэхэд 20-76 насны хүмүүс 50 хувь, 1-9 насны хүүхэд 50 хувийг тус тус эзэлж байна. Эмийн бүлгээр нь судлахад гарсан гаж нөлөөний 40 хувийг цефалоспорины бүлэг, 20 хувийг Пенцеллины бүлэг, 40 хувийг бусад эмийн бүлэг эзэлжээ. Мөн хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээний талаар хяналт хийхэд эмийг буруу хэрэглэж байгаа 70 өвчтөн, эмчилгээтэйгээ хавсран дураараа нэмж эм ууж байгаа 15 өвчтөн, антибиотик дураараа хэрэглэсэн 55 өвчтөн байсан байна. Иймээс өвчтөнд эмийг зөв хэрэглэх, хоол ундтай хэрхэн уялдуулах, ямар шингэнээр даруулан уух, эмийн шимэгдэлтэнд нөлөөлөх архи тамхи, хүчтэй исгэлэн зүйл хэрэглэхгүй байх талаар сургалтанд хамруулжээ.

2.3.8 Иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, эмчилгээг чанар хүртээмжтэй хүргэх зорилгоор томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлтийн үед хүүхдийн нэмэлт тасаг ажиллуулж байгаатай холбоотойгоор тендерийн эмийн хүрэлцээ хангамж дутагдаж байна. Эмнэлэгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор дутагдалтай эм, эмнэлэгийн хэрэгслийг эмийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжээс зээлээр авдаг байна.

2.3.9 Тендер сонгон шалгаруулалтаар нийлүүлэгдсэн эмийн хүрэлцээ дутмаг, тендерийн багцад нэр төрөл нь заагдаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл шаардлагатай үед иргэд, үйлчлүүлэгчдээс гаргуулах тохиолдол үүсэж байгаа бөгөөд иргэд хууль эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг буцаан нэхэмжлээгүй байна. Иймээс иргэдэд шинээр батлагдсан гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль эрх зүйн актыг таниулан сурталчлах ажлыг тухай бүр зохион байгуулж ажиллах нь зүйтэй юм.

2.3.10 Иргэдэд үзүүлэх эмчилгээний төрөл нэмэгдэж байгаатай холбогдуулан тендер сонгон шалгаруулалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ хангамжийг бодитой тодорхойлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлтэй уялдуулах шаардлага үүссэн байна.

## 2.4 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар В, С вирусын шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагджээ.

2.4.1 Шаардлагатай хөрөнгийн судалгааг тасаг нэгж бүрээр гаргаж ЭМЯ, ЭМГ, аймгийн ЗДТГ-т хүргүүлжээ.

2.4.2 Тайлант онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 41.7 сая, Япон улсын ард түмний тусламжаар 134.9 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 336.4 сая төгрөгийн эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

2.4.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 299.2 сая төгрөгийн В С вирусын шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан нь иргэд орон нутагтаа вирусын шинжилгээнд хамрагдах, өвчлөлийг эрт илрүүлэн оношилж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд цаг алдалгүй хамрагдах үр дүнтэй ажил болсон байна.

2.4.4 Одоогоор халдваргүйтэл, ариутгалын нэгдсэн угаалгын тоног төхөөрөмж нэн шаардлагатай байна. Тус тоног төхөөрөмжөөр хангагдсанаар эмнэлгийн ахуйн хэрэглэгдэхүүнийг стандартын дагуу ариутгал, халдваргүйдэл хийгдэх ач холбогдолтой юм

## 2.5 Тасгууд үйл ажиллагааны тайлангаа харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлан бичиж хэвшээгүй байна.

Аудитад мэдрэл, дотор, хүүхэд, мэс засал, яаралтай түргэн тусламж, онош зүйн тасгийн үйл ажиллагааг хамрууллаа.

2.5.1 Нэгдсэн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчдийн тасагт 108 эмч, сувилагч, асрагч эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд 7829 иргэн хэвтэн эмчлүүлж, яаралтай тусламж үйлчилгээг 9199 хүнд хүргэсэн байна.

Аудитад хамрагдсан тасаг нэгжийн үйл ажиллагааны талаар товч дурьдвал:

2.5.2 **Яаралтай түргэн тусламж:** Тус тасаг нь тайлант оны эхний 11 сарын байдлаар

| Агуулга            | он          |              |              |
|--------------------|-------------|--------------|--------------|
|                    | 2015        | 2016         | 2017         |
| ЯТТ-аар үзүүлэгсэд | 3503        | 13002        | 8963         |
| Төвийн дуудлага    | 5202        | 5914         | 6065         |
| Алсын дуудлага     | 444         | 488          | 494          |
| <b>Нийт</b>        | <b>9149</b> | <b>19404</b> | <b>15522</b> |

давхардсан тоогоор 15522 иргэнд яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлснээс яаралтай түргэн тусламжаар үзүүлэгсэд 57.7 хувь, төвийн дуудлага 39.1 хувь, алсын дуудлага 3.2 хувийг эзэлж байна. Яаралтай түргэн тусламжийн тоон үзүүлэлтийн өмнөх онуудтай харьцуулж үзвэл: Төвийн дуудлага өмнөх жилүүдээс

өссөн нь Баруун-Урт сумын оршин суугчдын тоо нэмэгдсэн, малчид өвлийн улиралд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамруулах зорилгоор төвд суурьшиж байгаа нь нөлөөлж байна. Яаралтай тусламжийн тасгаар үзүүлэгсдийн тоо эрс өсч байгаа нь ажлын цагаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадаагүй иргэд 18 цагаас хойш ирж үзүүлдэг нь нөлөөлж байна. Яаралтай тасгийн үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэх зорилгоор яаралтай тусламжийн нарийн мэргэжлийн их эмч, бага эмч нарыг ажиллуулж байгаа нь давуу тал болсон байна.

Тус тасгийн алсын дуудлагын зарим авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан, олон жил ашиглагдсан, эвдрэл гэмтэл байнга гарч байгаа нь яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хүндрэл бэрхшээл үүссэн байна.

Иймд дээрх нөхцөл байдалд үндэслэн орон нутгийн удирдлага болон ЭМЯ, ЭМГ-т хүсэлт гаргаж авто тээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагыг уламжлан, санал өгөх нь зүйтэй байна.

**2.5.3 Дотрын тасаг:** Тус тасгаар 1385 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн бөгөөд хэвтэн эмчлүүлэгчдийн 40.2 хувь ЗСС, 20.5 хувийг ХШЭӨ, 16 хувийг ШЯЗӨ, 12 хувийг АЗӨ, 11.3 хувийг бусад төрлийн өвчин эмгэг эзэлж байна. Тасгийн тэргүүлэх өвчлөлийг өмнөх 2 жилтэй харьцуулж үзвэл. Хүснэгт №5

| Агуулга     | он   |      |      |
|-------------|------|------|------|
|             | 2015 | 2016 | 2017 |
| <b>ЗСС</b>  | 499  | 501  | 558  |
| <b>ХШЭӨ</b> | 309  | 308  | 285  |
| <b>ШЯЗӨ</b> | 251  | 245  | 228  |
| <b>АЗӨ</b>  | 147  | 163  | 167  |
| <b>НИЙТ</b> | 1206 | 1217 | 1238 |

ШЯЗӨ, АЗӨ өвчлөл нэмэгдсэн үзүүлэлтэй харагдаж байна. Энэ нь томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдсэн, зүрхний ЭХО аппарат шинээр ирж шинжилгээ оношлогоо хийгдэж өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хоол шингээх эрхтэний өвчлөлөөс дотоод шүүрлийн өвчлөл нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь иргэдийн амьдралын буруу хэвшил, хэт таргалалт, нийгмийн байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байна. Цаашид амбулаторийн тасагт дотоод шүүрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг тогтмолжуулж, дотоод шүүрэл, түүний сөрөг үр дагаварын талаарх сургалт сурталчилгааг иргэдэд хүргэх нь зүйтэй байна.

**2.5.4 Мэс заслын тасаг:** Тайлант онд 1223 иргэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 40.8 хувь гэмтэл, 40.2 хувьд яаралтай болон төлөвлөгөөт хагалгаа хийж 19 хувьд бусад төрлийн тусламж үйлчилгээг хүргэсэн байна. Эмчилгээний чанар, төрлийг нэмэгдүүлэх зорилгоор түгжээт мэс ажилбарын журам батлуулж 28 үйлчлүүлэгчдэд амжилттай хийж гүйцэтгэжээ. Мөн гурав дахь шатлалын эмнэлгээс нарийн мэргэжлийн эмч урьж шинээр 6 мэс хагалгааг хамтран гүйцэтгэсэн нь, цаашид дээрх төрлийн хагалгааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэх боломжтой болжээ. Мэс ажилбарын тоог нэмэгдүүлэн гүйцэтгэж байгаа нь иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх сайн талтай байна. Мэс заслын тасагт нийт 105 хүндрэлтэй хагалгаанд цаг алдалгүй орсон ба 3 дахь шатлалын эмнэлгийн их эмч нартай хамтран тархины тал бөмбөлөгийн харвалт ухаангүй 4 мэс заслын хагалгааг хийж амь насыг аварсан байна. Урологийн нарийн мэргэжлийн эмчтэй болсны үр дүнд дурангийн оношлуураар 5 үйлчлүүлэгчийг дурандаж 3 үйлчлүүлэгчдэд цистостомия гуурс байрлуулсан, бүдүүн шулуун гэдэсний хагалгаанд 6 хүнийг хамруулжээ. Мөн Дүрс оношлогооны эмчтэй хамтран ЭХО хяналтын дор бөөрний уйланхайг хатгаж соруулах 1 хүнд амжилттай хийсэн байна. Шинээр “Хөтөвч халдваргүйжүүлэх иж бүрдэл”, “Холголт цооролтоос сэргийлэх ивүүр”, “Өвчтөн зөөвөрлөх дамнуурга”, “Тархины хагалгаанд орж буй үйлчлүүлэгчдэд зориулсан толгойн ивүүр” зэргийг хийж сайн туршлагын санд бүртгүүлжээ.

**2.5.5 Хүүхдийн тасаг:** Уг тасгаар 1151 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн бөгөөд хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн 83.2 хувийг 0-5 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Тасгийн гаргасан статистик мэдээнээс үзэхэд хэвтэн эмчлүүлсэн өвчлөлийн 65.4 хувийг амьсгалын замын эмгэг, 20.4 хувийг мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэг эзэлж




байгаа бөгөөд 77.2 хувийг хүнд хүндэвтэр өвчтөн эзэлж байна. Хүнд хүндэвтэр өвчтөний тоо өндөр, амьсгалын замын өвчлөл буурахгүй байгаа нь томуу, томуу төст өвчний үүсгэгч вирус өөр, өөр төрөл байгаа бөгөөд иргэд дур мэдэн эмийн буруу эмчилгээ хийж байгаатай холбоотой байна. Тасгийн эмч, сувилагч нар эмнэлэгт байнга хэвтэн эмчлүүлдэг, өвчлөх давтамж ихтэй хүүхдийн судалгааг гаргаж 30 хүүхэд сонгон гурван ээлжээр “Нархан” түр сувилал ажиллуулсан байна. Сувилалд хамрагдсан хүүхдийн биеийн өндөр, жинг харьцуулж гаргасан бөгөөд судалгаанаас харахад 0,2-1,2 кг-аар өссөн үзүүлэлт гарчээ. Мөн сувилалд хамрагдсан хүүхдүүдийн дунд 2017-2018 оны томуугийн дэгдэлтийн үед тандалд судалгаа хийж үзэхэд хэвтэн эмчлүүлэх давтамж өмнөх оноос буурсан үзүүлэлттэй гарч байгаа нь үр дүнгээ өгсөн байна. Цаашид зуны түр сувиллын үйл ажиллагааг тогтмолжуулах талаар АЗДТГ, Баруун-Урт сумын ЗДТГ, ЭМГ-т хүсэлт гаргаж шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх, сувилалт хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулснаар өвчлөлөөс урьдчилан сэргийлж, бууруулах сайн туршлага болсон байна.

**2.5.6 Мэдрэлийн тасаг:** Мэдрэлийн кабинет нь 3506 хүнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 1578 хүн, өвчний учир 1662 хүн, идэвхитэй хяналт 266 хүнд тус тус хийсэн байна. Мэдрэлийн тасагт 2015-2017 онуудад нийт харвалтын тохиолдол 112 бүртгэгдсэн байна. Тайлант онд тархины харвалтын тохиолдол 11-р буурсан. Энэ нь сүүлийн жилүүдэд хийсэн харвалтын эрсдэлт хүчин зүйлүүд, даралт болон чихрийн шижин, зүрх судасны өвчний хүндрэлээс сэргийлэх чиглэлийн сургалтууд хийгдсэнтэй холбоотой. Тархины харвалтын нас баралт 2017 онд 2 тохиолдлоор нэмэгдсэн. Энэ нь хүн амын дунд ямар үед эмнэлэгт хандах, харвалт болж болзошгүй шинжийн талаарх мэдлэг хомстой холбоотой цаг алдаж эмнэлэгт хандах зэргээс болж байна.

**2.5.7 Онош зүйн тасаг:** Тайлант онд оношлогоо шинжилгээний 8 төрлийн тусламж үйлчилгээг нийт 92763 иргэнд үзүүлсэн байна. Нийгмийн даатгалаас авбал зохих санхүүжилт 319.1 сая төгрөгийг оношлогоо шинжилгээгээр нэхэмжлэж, төсөвт төвлөрүүлжээ. Бэлэн мөнгөний орлого КТГ-4.5 сая, урьдчилан сэргийлэх үзлэг 4.8 сая, цээж гэрэлд харах 1.2 сая, нийт 10.6 сая төгрөгний орлогыг АНЭ-ийн төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант онд 167.0 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл болон лабораторийн урвалж бодис ашиглажээ. Эхо үзлэгийн илрүүлэлт 2017 онд:

График №3





Цусаар дамжих халдвар илрүүлэх шинжилгээг ийлдэс судлалын чанарын гадаад үнэлгээг Австрали Улсын лавлагаа лаборатори болон ХӨСҮТөвийн сериологийн лавлагаа лабораторит хянуулан ажилладаг бөгөөд 2017 онд Гематологи биохимийн гадаад хяналтын үнэлгээ 1 удаа хийгдсэн байна. Түнхний ЭХО-оор нярай хүүхдийн түнхний үений дутуу хөгжлийг эрт дээр үед нь илрүүлж нийт 420 хүүхэд үзсэнээс түнхний үений дутмаг хөгжилтэй 32 хүүхдийг илрүүлсэн байна.

2.6.10. Аудитад Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга П.Болормааг шинжээч эмчээр татан оролцуулж мэдрэл, хүүхэд, дотор, мэс заслын тасгийн хэвтэн эмчлүүлэгчдийн өвчтөний түүхээс сонгон авч эмчилгээний стандартад нийцсэн эмчилгээ үзүүлж буй талаар дүгнэлт гаргуулахад дараах нийтлэг дутагдал гарсан байна. Тухайлбал:

- Эмчийн заасан эмчилгээг эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн хуудсанд бичихдээ эмийн нэрийг буруу бичсэн, сувилгааны үйл ажиллагааны 5-н шатлалаар тусламж үзүүлэхдээ зовиурыг багасгах, зөв сувилгааны асуудлыг сонгож хэрэглэж хэвшээгүй
- Өвчний түүхийг дутуу бичдэг ,ялангуяа зарим эрхтэн тогтолцооны үзлэгийг дутуу орхидог / арьс ,үе ,мөч,тунгалагийн тогтолцоо/
- Оношийн үндэслэлийг дутуу бичдэг / ялангуяа үндэслэл болохуйц, лабораторийн шинжилгээ, үйл оношийн шинжилгээ, бодит үзлэг, хэсэг газрын үзлэг /
- Антибиотик эмчилгээг хийх заалтгүй өвчтөнд хийсэн байна Тухайлбал: остеоартроз өвчний түүх хэд хэд байгаа бөгөөд мөн хэвтэх шаардлагагүй байна
- Өвчний оношинд тохирсон стандарт эмчилгээг бичиж байх, ялангуяа антибиотик эмчилгээг оношинд тохируулж ,тохирсон тунгаар авах зэрэг зөрчил дутагдал илэрчээ.

Аудитын түүврээр нийт хэвтэн эмчлүүлэгчийн өвчтөний түүхийн 0,1 хувийг авч үзэхэд дээрх зөрчил дутагдал илэрч байна. Түүврийн тархалтыг нэмэгдүүлсэн тохиолдолд дээрх зөрчил дутагдлууд өсөн нэмэгдэх таамаглал ажиглагдлаа. Иймд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ялангуяа чанарын хяналтыг сайжруулах, мэргэжлийн чиг үүрэг стандарттай холбогдуулан илэрсэн зөрчлүүдэд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх ажлаа төлөвлөх нь зүйтэй байна. Мөн тасаг нэгжүүд үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа өмнөх онуудын тоон үзүүлэлттэй харьцуулж өсөлт, бууралтыг тооцож дүн шинжилгээ хийгээгүй, тасгийн тэргүүлэх зэрэглэлийн өвчлөлийн судалгааг гаргасан байгаа боловч өвчлөл нэмэгдсэн шалтгааныг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх ажлыг нарийвчлан тооцож төлөвлөж, ажиллаагүй, зарим эмч өвчний түүхийг стандартын дагуу бүрэн хөтлөөгүй байна.

## **2.6 Тасгийн эрхлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.**

2.6.1 Нэгдсэн эмнэлгийн 2015 оны А/48<sup>24</sup> тушаалаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны орон тоо, бүтэц, үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан байна.

<sup>24</sup> Чанарын албыг шинэчлэн байгуулах тухай

Энэхүү тушаалаар чанарын хяналтын орон тооны 2, орон тооны бус 9, тасаг нэгжүүдэд 3-5 хүний бүрэлдэхүүнтэй нэгжийг байгуулсан байна.

2.6.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын хяналтыг Шадар сайд, ЭМС-ын хамтарсан 2012 оны 06/25<sup>25</sup> тоот тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, халдвар хамгаалал, сувилахуйн алба гэсэн чиглэлээр явуулж байна.

2.6.3 Чанарын менежер тасаг нэгжүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт явуулж гарсан алдаа зөрчлийг ЭМС-ын 2012 оны 274<sup>26</sup> тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу бүртгэж байна.

2.6.4 Чанарын албанаас хяналтыг хийж гарсан алдаа зөрчлийг газар дээр нь арилгуулах болон зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж хүргүүлж байна. Тухайлбал: эмийн зохистой хэрэглээнд хийсэн хяналтаар дараах зөрчил дутагдал гаргасанд зөвлөмж хүргүүлжээ.

- Тасаг нэгжүүдийн яаралтай тусламжийн шүүгээнд зайлшгүй байх эм тарианы нөөц бүрдүүлдэггүй байсныг арилгуулснаар яаралтай амь тэнсэн үеийн эмчилгээг цаг алдалгүй хүргэх нөхцөл боломж бүрдүүлсэн байна.
- Эмч нарын бичсэн өвчтөний түүхийг хянахад 70-аас дээш настай өвчтөнд эмийн тунгийн зохицуулалт хийдэггүй, антибиотик эмийг олон хоног хяналтгүй хийдэг, эмийн харилцан үйлчлэл, эмийн шимэгдэлтэнд нөлөөлөх эмийг хавсруулан хэрэглэсэн
- Зарим тасаг нэгж эмийн гаж нөлөөллийг мэдээлдэггүй зэрэг алдаа зөрчил гаргасан байна.

Мөн антибиотик эмийн зохистой хэрэглээний судалгааг гаргахын тулд сүүлийн 3 сарын жоронд судалгааг хийхэд 140 зөрчил илэрсэн ба антибиотик эмүүдийг ихээр бичиж өгсөн байна. Үүний 91 зөрчил буюу 66.4 хувийг 1-6 насны хүүхдэд антибиотик эм бичсэн нь эзэлж байна. Мөн тасаг нэгжийн зайлшгүй байх шаардалагатай эм тарианы бүрдүүлэлтэнд хяналт хийж эм, тарианы нөөцийг тухай бүр бүрдүүлж хэвшсэнээр амь тэнсэн үеийн яаралтай тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх боломж бүрджээ. Клиник эм зүйчийн 2018 оны эхний улирлын зарим хэвтэн эмчлүүлсэн өвчтөний түүхэнд хяналт хийж эм тариа хоорондын үл нийцлийн эмийн эмчилгээний судалгаа дүгнэлтэд ихэнх өвчтөний түүхэнд үл нийцэл илрээгүй боловч зарим тохиолдолд эм тариа хоорондын үл нийцэл илэрсэн нь харагдаж байна. Чанарын хяналтаар илэрсэн алдаа зөрчил арилгуулах зөвлөмж хүргүүлж байгаа ч алдаа зөрчлийг давтан гаргасан, зөвлөмж хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.

2.6.11 Чанарын хяналтын албан хяналт шалгалтын тайлан, клиник эм зүйчийн гаргасан дүгнэлтээс үзэхэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ эмчилгээний стандарт болон эмийн зохистой хэрэглээ алдагдах нөхцөл байдалтай байна.

2.6.12 Иймээс чанарын хяналтын тайлан, клиник эм зүйчийн эм тариа хоорондын үл нийцлийн судалгаа дүгнэлтийг цаг тухай бүр чанарын алба, удирдлагын зөвлөл, эмч

<sup>25</sup> Чанарын албаны дүрэм батлах тухай

<sup>26</sup> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний алдаа зөрчлийг бүртгэх, мэдээлэх заавар

нарын хурлаар хэлэлцэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар онцгой анхаарч ажиллах нь зүйтэй байна.

2.6.13 Мөн чанарын менежерийг эмнэлгийн аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой комисст /тооллогын комисс, хөрөнгө хүлээн авах комисс гэх мэт/ томилон ажиллуулж байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээнд тавих хяналтыг сулруулах сөрөг үр дагавартай тул цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

2.6.14 Тасаг нэгжийн үйл ажиллагааны өдөр тутмын хяналтыг ахлах сувилагч хийж байгаа бөгөөд ихэнх тасгийн эрхлэгч, зөвлөх эмч хяналтыг тогтмол хийдэггүй нь тасагт хөтлөгдөж буй дотоод хяналтын журналаас харагдаж байна.

2.6.15 Цаашид эмнэлгийн даргын 2015 оны А/48<sup>27</sup> тушаалаар томилогдсон тасаг нэгжийн чанарын хяналтын хэсгийн ажлыг төлөвлөгөө, тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг тооцож, эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй хүргэхэд анхаарах нь зүйтэй юм.

**3**

**Дэд зорилт-3: Удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааны үр дүн**

**БҮЛЭГ 3**

*Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө гарган ажиллаж байгаа боловч ихэнх ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж дундажаас доогуур, ёс зүйн зөрчил гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хариуцлага тооцох талаар хангалтгүй ажиллаж байна.*

**3.1 Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд хийгдэхээр төлөвлөгөөний биелэлтийг 90.2 хувиар хангаж, хэрэгжилтийг удирлагын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэжээ.**

3.1.1 ЭМ-ийн тусламж үйлчилгээний шатлал хоорондын хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд сум, өрхийн ЭМТөвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, “Эх барихуйн яаралтай тусламж”, “НЭҮНШТусламж” Эрхтэн тогтолцооны эмгэг” зэрэг ажлын байрны, “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-ыг зайны сургалтаар хүргэж эх нярайд үзүүлэх тусламж болон НЭМ-ийн тусламж үйлчилгээний чанарт анхаарч ажиллажээ.

3.1.2 Эх хүүхдийн эндэгдлээс сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажиллаж байна. Баталсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал:

- Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд төрөх өрөөний цомгийн хангалт, ариун бээлий, нэг удаагийн хэрэгслээр 100% хангаж байгаа ба шинээр Кофейн цитрат тариа, глюкоз, Пантоген, Хемоклет, Нольпаза зэрэг эм тариануудыг хэрэглэсэн нь эх нярайн тусламжинд үр дүнтэй байна. Тайлант оны 10 сард эхийн эндэгдэл

<sup>27</sup> Чанарын алба шинчлэн байгуулах тухай

гарсантай холбогдуулан шуурхай ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.

- Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд орон тоогоор НЭМ-ийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний ажлын байрыг шинээр бий болгож иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааны давтамжийг нэмэгдүүлсэн байна. Жирэмсний эрхтэн тогтолцооны эмгэгийн кабинетийг төрөх тасгийн амбулаторит тусад нь ажиллуулснаар жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх хандлагатай байна.
- Эмийн бус эмчилгээний үйл ажиллагааг тасралтгүй явуулах, эмчилгээ, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх зорилгоор уламжлалтын их эмчийг Бээжин хотод зүү төөнүүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж “Туниа массаж” орон нутагтаа нэвтрүүлжээ. Мөн СЗЭ-ний 1 их эмч, 1 сувилагчийг ӨМӨЗОрны Хөлөнбуйр аймагт уламжлалт анагаах ухааны чиглэлээр, нугасны гэмтлийн үеийн СЗЭ-ний сургагч багш бэлтгэх сургалтанд 2 хүнийг, хүүхдийн гэмтэл согог, гэмтлийн дараах нөхөн сэргээх эмчилгээний сургалтанд 2 их эмчийг тус тус хамруулжээ.
- ЭМСайдын 2016 оны А/147<sup>28</sup> тоот тушаал, АЗДаргын 2017 оны А/201<sup>29</sup> тоот захирамжийн дагуу “Явуулын амбулаторийн үзлэг оношлогоо”-г Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Дарьганга, Түвшинширээ, Онгон, Баяндэлгэр, Мөнххаан, Баруунурт, Сүхбаатар, Асгат зэрэг 10 суманд нийт давхардсан тоогоор 22000 гаруй иргэнийг үзлэг, шинжилгээнд хамруулжээ.
- Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг тасралтгүй хийж умайн хүзүүний эсийн шинжилгээ хийлт улсын дундаж 46.1 хувь, АНЭ 72.3 хувь, хөхний үзлэг, эмэгтэйчүүдийн үзлэг, артерийн даралт ихсэх, чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэг, эмчилгээ, хяналтыг журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.
- ЗГ-ын 2017 оны 12 тоот тогтоол “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны 14809 иргэнд элэгний В,С вирусын шинжилгээ хамруулснаас В вирустай 1291, С вирустэй 1169 хүн илэрсэн байна. Нэгдсэн эмнэлгийн лаборатороос нийт НСҮ эерэг 1132 сорьцыг ачаалал тоолуулах шинжилгээнд илгээсэн.

3.1.3 Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд хийгдэхээр төлөвлөгөөний биелэлтийг 90.2 хувиар хангаж, хэрэгжилтийг удирлагын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэжээ. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гарган ажилласнаар иргэдийн дунд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг хийж, илэрсэн өвчлөлийг цаг хугацаа алдалгүй, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах үр дүнтэй ажил зохион байгуулсан байна.

## 3.2 Зарим албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод ажлын чиг үүргийн давхардал гарч байна.

3.2.1 Аймгийн нэгдсэн эмнэлгийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 тогтоолын 1<sup>30</sup>, 2<sup>31</sup> хавсралт, Эрүүл мэндийн

<sup>28</sup> Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх журам

<sup>29</sup> Эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх тухай

<sup>30</sup> Ажлын байрны тодорхойлолтын загвар

<sup>31</sup> Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар

сайдын 2011 оны 67<sup>32</sup> тоот, 2012 оны 183<sup>33</sup> тоот тушаалаар батлагдсан үлгэрчилсэн загварын дагуу боловсруулж баталгаажуулсан байна.

3.2.2 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг түүвэрлэн үзэхэд тооцооны нягтлан бодогчдын ажлын чиг үүргийг зааглаж тодорхой тусгаагүй, үндсэн хөрөнгө хариуцсан нярвын ажлын байрны тодорхойлолтонд мөнгөн кассын нярвын үйл ажиллагааны зорилтыг тусгасан, үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалттай холбоотой нэг заалтыг ерөнхий байдлаар тусгасан, хүний нөөцийн менежер болон архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтонд зарим ажлын чиг үүргийг давхардуулсан байна.

3.2.3 Зарим албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулаагүй, ажил үүргийг давхардуулсан нь иргэдэд хүрэх үйлчилгээ цалгардах, төсөв хөрөнгөтэй холбоотой болон хугацаатай тооцоо судалгааны ажил орхигдох эрсдэлтэй байна.

3.2.5 Тасаг нэгжийн эрхлэгч эмч болон тасгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтонд дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт тусгагдаагүй байсан боловч 2018 онд шинэчлэн баталсан ажлын байрны тодорхойлолтоор тасаг нэгжийн эрхлэгч эмчид дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх заалтыг тусгаж өгсөн байна.

### 3.3 Статистик мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хэвшжээ.

3.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлэг нь статистик мэдээ тайланг ЭМС-ын 2013 оны 450<sup>34</sup> тоот тушаалаар батлагдсан журмын дагуу нэгтгэн ЭМТ-501.1<sup>35</sup>, ЭМТ-201<sup>36</sup> маягтын дагуу гарган тайлагнаж [www.hinfo.3](http://www.hinfo.3) цахим программд мэдээлж байна.

3.3.2 ЭМС-ын 2014 оны 358<sup>37</sup> тоот тушаалын дагуу томуугийн мэдээллийг өдөр бүр, эх хүүхдийн эрүүл мэндийн мэдээ мэдээллийг ЭХЭМҮТ-ийн даргын А/207<sup>38</sup> тоот тушаалын дагуу 7 хоног бүр [www.ehemvt.mn](http://www.ehemvt.mn) цахим сайтад мэдээлж байна.

3.3.3 Мөн ЭМТ-502<sup>39</sup> маягтаар халдварт бус өвчлөл, ЭМТ-503<sup>40</sup> маягтаар хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн судалгааг гаргаж холбогдох дээд шатны байгууллага болон эмч, эмнэлгийн ажилчдыг мэдээллээр хангаж байна.

3.3.4 Тайлант онд гаргасан статистик мэдээ, мэдээллийг анхан шатны журнал, баримттай тулган баталгаажуулахад 6 сард үзлэгт хамрагдсан хүний тоо 1940 хүнээр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь хөдөөгийн сумдад явуулын амбулаториор үзлэг, оношлогоо шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж /интернэт, зөөврийн компьютер/ дутагдалтай байгаагаас үйлчлүүлэгчийн мэдээллийг цахим

<sup>32</sup> “Эмнэлэгийн зарим мэргэжилтний болон эмнэлэгийн бус зарим ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар” батлах тухай

<sup>33</sup> Сувилагч, эмнэлэгийн тусгай мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай

<sup>34</sup> Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журам

<sup>35</sup> Сарын мэдээ

<sup>36</sup> Жилийн эцсийн мэдээ

<sup>37</sup> Томуугийн тандалтын бүртгэл

<sup>38</sup> Эх хүүхдийн эрүүл мэндийн бүртгэл

<sup>39</sup> Халдварт бус өвчлөлийн тайлан

<sup>40</sup> Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тайлан

программд цаг тухай бүр шивэгдээгүй, дараагийн саруудад нөхөж оруулж байгаатай холбоотой байна.

3.3.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоон мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж, тоон үзүүлэлтийг өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулж байгаа боловч тасаг нэгжийн нарийн мэргэжлийн эмчийн хүрэлцээ хангамж, эмнэлгийн тусламж үйлчилгээний өвчлөлийн өссөн буурсан шалтгааныг тооцож, дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход ашиглаагүй байна.

3.3.6 Мөн ЭМТ-501 маягтаар гаргасан мэдээг байгууллагын ил тод байдлын самбарт сар бүр шинэчлэн байршуулж байна. Гэвч тайлант онд хийж хэрэгжүүлсэн ажил, статистик тоон мэдээлийн талаар орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх талаар учир дутагдалтай байна.

### 3.4 Тайлант онд 14 иргэнийг түр ажлын байраар хангажээ.

3.4.1 Нэгдсэн эмнэлэг нь 2017-2021 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулан батлуулжээ. Хүний нөөцийн хөтөлбөрийн дагуу дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор НЭМ-ийн сургалт хариуцсан ажилтан, хог хаягдал хариуцсан ажилтан, төрөх эмэгтэйчүүдийн тасагт үйлчлэгч, туслах сувилагч нарын орон тоог нэмэгдүүлжээ.
- Тасгийн сувилагч, асрагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор сувилахуйн албатай хамтран тасаг хооронд сэлгүүлэн ажиллуулсан байна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхээр Халдварт, Зүү төөнүүр судлал, Мэс заслын эмч, Дотор судлал, Эрчимт эмчилгээ, Нүүр амны мэс засал судлал, ЭБЭ-ийн эмчийн нарийн мэргэжил олгох сургалтанд хамруулаад байна.
- Ажлын байран дах тасралтгүй сургалтын төлөвлөгөөг гарган ажиллаж дотоодын сургалтанд 14 сэдвээр 8 удаагийн давхардсан тоогоор 395 хүнд, танхимын сургалт 17 удаа 930 хүнд тус тус явуулсан байна. Эмч мэргэжилтнүүдийг гадаад сургалт болон туршлага солилцохоор Тайвань, Болгар, Тайланд, БНХАУ-ын Хөлөнбуйр хотод тус тус суралцуулсан байна.
- Мөн эмч, сувилагчийн эмчлэх эрхийн судалгааг гаргаж, эмчлэх эрхийн хугацаа дуусахаас өмнө сургалтанд хамруулсайд байна.

3.4.2 Эмч, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх зорилгоор эмч, сувилагч, тасаг нэгжийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

3.4.3 Ажлын байрны сонгон шалгаруулалтыг Төрийн албан тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гарсан холбогдох стандартын дагуу хэрэгжүүлээгүй, байгууллагын баталсан дүрэм журмыг мөрдлөг болгож байна. Энэ нь төрийн албаны стандарт, нийтэд ажлын байрыг нээлттэй зарлах, сонгон шалгаруулах зэрэг үйл ажиллагааг алдагдуулж байна. Эмнэлгийн ажилчдын сонгон шалгаруулах журмыг хууль тогтоомжтой уялдуулан боловсронгуй болгох, нийтэд нээлттэй байлгах нь төрийн албаны стандарт, дүрэм журмыг хангах нэг ажил болох юм.



3.4.4 Хүний нөөцийн бодлогын хүрээнд эмч, эмнэлгийн ажилчдын мэргэжил арга зүйг дээшлүүлэх сургалт, сувилагчийн ур чадварын нэмэгдүүлэх, тасаг хооронд сэлгэн ажиллуулах, эмчлэх эрхийн хугацаа дууссан эмч эмнэлгийн мэргэжилтэнг шалгалтанд хамруулах үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч ажлын байрны сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй байна. Мөн ажилд орохыг хүссэн өргөдөл ирүүлсэн иргэдийн дунд ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулж нөөцөд бүртгэх нь зүйтэй юм.

### 3.5 Нийт бүртгэгдсэн өргөдлийн 34.9 хувь буюу 72 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

3.5.1 Тайлант онд иргэн, ажилтан албан хаагчдаас ажил хүссэн, тэтгэмж, захиргааны болон хүүхэд өсгөх чөлөө хүссэн зэрэг 206 өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэж шийдвэрлэсэн байна. Ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

Хүснэгт № 6

| Төрөл                | Ирсэн өргөдөлийн тоо | Эзлэх хувь | Шийдвэрлэсэн байдал  |
|----------------------|----------------------|------------|--|
| Ажилд орохыг хүссэн  | 25                   | 12.1       | Ажилд орохыг хүссэн өргөдлийг хүний нөөцийн менежер судлан хариуг хүргүүлсэн байна.  |
| Сургалтанд хамрагдах | 24                   | 11.7       | Эмч, эмнэлгийн ажилчдаас сургалтанд хамрагдах өргөдлийг хянан үзэж сургалтын төлөвлөгөө хөтөлбөртэй уялдуулан дэс дараатайгаар хамруулж байна.   |
| Ажлаас чөлөөлөгдөх   | 23                   | 11.2       | Хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн.  |
| Хүсэлт гаргасан      | 30                   | 14.6       | Тасаг нэгжүүдээс ажлын байрны нөхцлийг сайжруулах, ажилчин албан хаагчдаас ажлын нөхцлийг өөрчлөх хүсэлт гаргасаны дагуу батлагдсан төсөв, бүтэц орон тоонд тулгуурлан шийдвэрлэсэн.                         |
| Чөлөө хүссэн         | 32                   | 15.5       | Албан хаагчдаас хүүхэд асрах 6-24 сарын чөлөө хүссэн бөгөөд ажлын ачаалал, хүний нөөцөд тулгуурлан чөлөөг олгосон.   |
| Тэтгэмж авах         | 64                   | 31.1       | Эмч, эмнэлгийн ажилчдаас тэтгэвэрт гарахад болон орон нутагт 5 жил ажилласны мөнгөн тэтгэмж хүссэн өргөдөл гаргасан бөгөөд тэтгэмж олгоход шаардлагатай баримт материалыг хүлээн авч ЭМГ-т хүргүүлсэн байна. |
| Бусад                | 8                    | 3.8        | Энэ төрөлд хандив хүссэн болон иргэдээс гаргасан санал гомдол багтаж байгаа бөгөөд холбогдох албан тушаалтанд хариуцуулж шийдвэрлүүлсэн байна.   |
| <b>БҮГД</b>          | <b>206</b>           | <b>100</b> |  |

3.5.2 Нийт ирсэн өргөдлийн 65 хувь буюу 134 өргөдлийг барагдуулж 35 хувь буюу 72 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна. Шийдвэрлэх шатандаа байгаа 72 өргөдлийг авч үзвэл: Тэтгэвэрт гарахад болон орон нутагт 5 жил ажиллахад олгодог мөнгөн тэтгэмжтэй холбоотой тул баримт материалыг бүрдүүлэн ЭМГ-т хүргүүлж судалгаанд хамруулсан бөгөөд төсөв хөрөнгө, эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй холбоотойгоор хүлээгдэж байна. Мөн сургалтанд хамрагдах хүсэлт гаргасан 8 өргөдөл байгаа бөгөөд 2018 оны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

3.5.3 Нийт ирсэн өргөдлийг бүртгэж, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл,

гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16.1<sup>41</sup>, 16.2<sup>42</sup> заасны дагуу хариуг хүргүүлсэн байна.

### 3.6 Иргэдээс бичгээр болон амаар ирсэн санал гомдолд үндэслэн ёс зүйн алдаа гаргасан эмч, эмнэлгийн ажилтанд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

3.6.1 Аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлага, чанарын менежерт иргэдээс бичгээр 5 гомдол, албан хаагчдын маргаантай холбоотой 1 гомдол ирсэн байна. Мөн чанарын менежерт биечлэн болон санал хүсэлтийн хайрцагаар 68 санал хүсэлт, гомдол гаргасан байна. Харин аймгийн ёс зүйн салбар хороо болон нэгдсэн эмнэлгийн ёс зүйн хэсгийн хороонд бичгээр болон амаар санал гомдол гаргаагүй байна.

3.6.2 Өргөдөл, бичгээр ирсэн санал хүсэлтийг эмчилгээ эрхэлсэн орлогч, чанарын менежер хариуцан шийдвэрлэж байгаа бөгөөд ихэнх гомдол эвлэрүүлэн зуучлахаар зохицуулж ажиллаж байна. Харин 1 өргөдлийн хариуг албан тоотоор хүргүүлж алдаа зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцсон байна.

3.6.3 Санал гомдлын хайрцагаар болон амаар ирсэн 68 санал гомдлыг ангилан авч үзвэл талархал 5 буюу 7.3 хувь, хүлээгдэл үүсгэсэн 31 буюу 45.6 хувь, зан харилцааны болон ёс зүйн зөрчилтэй холбоотой 32 буюу 47.1 хувийг эзэлж байна.


3.6.4 Амаар гаргасан санал гомдлыг чанарын менежер тусгайлан тэмдэглэн авч алдаа зөрчил гаргасан эмч, эмнэлгийн ажилтантай болон гомдол гаргасан иргэдтэй уулзаж учир шалтгааныг тодруулж, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулсан байна.

3.6.5 Ёс зүйн зөрчил дутагдал гаргасан эмч, эмнэлгийн ажилтныг аймгийн ёс зүйн салбар хороо болон хэсгийн хороонд шилжүүлж ёс зүйн алдаа зөрчлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлээгүй байна.

3.6.6 Иргэдээс ирсэн санал гомдолд үндэслэн хүлээгдэл үүсгэсэн, ажлын цаг ашиглалт баримтлаагүй 1 эмчид сахилгын шийтгэл оногдуулсан бөгөөд ёс зүйн алдаа зөрчил гаргасан эмч, эмнэлгийн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулаагүй харин ажилтны үр дүнгийн урамшууллаас хасаж тооцох арга хэмжээ авч ажилласан байна.

Иргэдээс бичгээр болон амаар гаргасан санал гомдлыг өмнөх онтой харьцуулж үзэхэд:

График №4



3.6.7 Ёс зүйн харилцаа хандлагатай гомдол санал өмнөх оноос 76.2 хувиар өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Өмнөх онуудад эмч, эмнэлгийн ажилчдад ёс зүйн харилцаа, хандлагатай сургалтыг 12 төрлөөр явуулж давхардсан тоогоор 745 албан хаагч хамрагдсан боловч ёс зүйн алдаа зөрчлийн тоо буурахгүй байгаа нь сургалтын чанар үр дүн хангалтгүй байгаа нь харагдаж байна.

<sup>41</sup> Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

<sup>42</sup> Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө

3.6.8 Нэгдсэн эмнэлгээс авсан сэтгэл ханамжийн судалгаа, аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатанд эмч, эмнэлгийн ажилчидтай уулзаж чөлөөт ярилцлага зохион байгуулахад ажлын байрны сэтгэл ханамж дундажаас доогуур түвшинд байгаа харагдсан. Тухалбайл: сувилагч, асрагч нарын илүү цагийн нэмэгдлийг тухайн сард бодож олгодоггүй, ажлын ачаалал ихтэйгээс захиргааны чөлөө авахад хүндрэлтэй, ихэнх тасаг нэгжүүдэд амрах өрөө болон хувцас солих өрөө байхгүй, жижүүрийн эмч нарт хоол өгч байгаа боловч ээлжийн сувилагчдад өгдөггүй зэрэг асуудлыг дэвшүүлж байна.

3.6.9 Иймд эмнэлгийн удирдлага, удирдлагын зөвлөл ажилчдын санаа бодлыг нээлттэй сонсож хүлээн авах, дэвшүүлсэн санал санаачлагыг хэлэлцүүлэх, ажилчдын ажиллах нөхцөл боломжинд тулгуурлан урамшуулах, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- *Хүний нөөцийн хэрэгцээ шардлагыг бодитой тодорхойлоогүйгээс нарийн мэргэжлийн эмч нарын ажлын ачаалал нэмэгдэж эмчилгээний стандартад эрсдэл гарах нөхцөл бүрдсэн байна.*
- *Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр гадаад болон дотоодын сургалтуудад үе шаттай хамруулж байгаа боловч үйлчилгээний чанар хүртээмж сайжрахгүй байна.*
- *Эмнэлгийн эмч, албан хаагчдыг ажилд авахдаа нээлттэй ил тод сонгон шалгаруулалт хийхгүй байгаа нь Төрийн албаны стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.*
- *Ёс зүйн зөрчил гаргасан эмч, сувилагчид хариуцлага тооцож, ажлын үр дүнг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт доголдол гарах, иргэдэд хүлээгдэл, хүнд суртал үүсгэсэн хэвээр байна.*

## ЗӨВЛӨМЖ

*Төсөв санхүүгийн чиглэлээр*

1. *Үйл ажиллагааны орлогыг /төлбөртэй үйлчилгээний орлого/ тухай бүр харилцах дансанд байршуулж төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж, ажилчин албан хаагч болон харилцагч байгууллагатай холбоотой үүссэн өглөгийг баталгаажуулж санхүүгийн тайланд илэрхийлэх.*
2. *Шинээр батлагдан гарсан болон өөрчлөлт орсон төсөв санхүүгийн холбогдолтой эрх зүйн актыг тухай бүр албан хаагчдад танилцуулж хэвших*
3. *Дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглагдах боломжгүй 71.4 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн*

*тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагад санал хүргүүлэн,  
шийдвэрлүүлэх*

#### *Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр*

- 1. Статистик мэдээ тайланд үндэслэн амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэгчийн тэргүүлэх чиглэлийн өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулж, харьцуулсан дүн шинжилгээг хийж хэвших*
- 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй уялдуулан сургалтын чанар үр дүнг тооцож байх*

#### *Чанарын хяналтын чиглэлээр*

- 1. Чанарын хяналтаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож, сахилга хариуцлагыг дээшлүүлэх.*
- 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд бодлого арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжилтийг хангуулах, тасаг нэгжийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд тавих хяналтыг эрчимжүүлэх*
- 3. Ёс зүйн зөрчил гаргасан эмч, эмнэлгийн ажилтныг нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн хэсэгт шилжүүлж, хариуцлага тооцуулж байх*
- 4. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчтөний түүх бичилтийг стандартын дагуу үнэн зөв, бүрэн бөглөж хэвших.*

#### *Бусад чиглэлээр*

- 1. Худалдан авах ажиллагааны сургалтанд албан хаагчдыг хамруулж хуулийн хүрээнд сонгон шалгаруулалтыг үнэн зөв гүйцэтгэх*
- 2. Өмч хамгаалах байнгын зөвлөл, тооллогын комиссын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг дээшлүүлэх*
- 3. Зарим ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтоны чиг үүргийн давхардлыг арилгаж, ажлын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх*

## Шалгагдагч байгууллагаас ирсэн санал

### СҮХБААТАР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг  
Утас, факс: 70518652

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2018.06.27 № 276

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлбар хүргүүлэх тухай.

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газраас тус нэгдсэн эмнэлгийн 2017 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааны үр нөлөөт байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаж зөвшөөрч хүлээн авлаа.

Зарим заалтуудад дараах тайлбарыг хүргүүлж байна.

1.3.6 дахь заалтын 3.6.8 Тухайлбал сувилагч, асрагч нарын илүү цагийн нэмэгдлийг тухай сард бодож олгодоггүй, ажлын ачаалал ихтэйгээс захиргааны чөлөө авахад хүндрэлтэй ихэнх тасаг нэгжүүд амрах өрөө болон хувцас солих өрөө, байхгүй жижүүрийн эмч нарт хоол өгч байгаа боловч ээлжийн сувилагчдад өгдөггүй зэрэг асуудлыг дэвшүүлж байна.

Үүнд: Тус нэгдсэн эмнэлэг нь 2017 онд нийт 332 хүнд давхардсан тоогоор захиргааны чөлөөг олгосон. Харин урт хугацааны буюу 1 сараас дээш чөлөөг 5 хүнд олгосон. Байгууллагын хамтын гэрээнд тусгасны дагуу 99 хүнд 5-7 хоногийн цалинтай чөлөөг олгож 12 сая төгрөг зарцуулсан байна. Харин чөлөө олголт хэт их өгснөөс зарим ажиллагсад хэт ачаалал үүсэх, зарим нэг нь чөлөөг дахин дахин авч байгууллагын дүрэм журмыг зөрчих, сахилга хариуцлагын дэг журмыг алдагдахад хүргэж байна.

3.6.9. дахь заалт Ажиллагсдын ажиллах нөхцөл боломжинд тулгуурлан урамшуулах, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

Албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч тэдэнд ажиллах эрч хүч хүсэл эрмэлзэл бий болгоход анхаарч аймаг орон нутгийн удирдлагууд, бусад төр засгийн байгууллагуудтай хамтран дэмжиж ажилласны үр дүнд 2017 онд Төрийн дээд шагнал Гавъяат эмч 1, Алтан гадас 2, Хөдөлмөрийн хүндэт медаль 5, ЭХТажилтан цол тэмдэг 17, ЭМЯамны Жуух бичиг 22, АШУУИС-ийн шагналаар 3 хүн, МСН шагнал 5, САТөв 3 хүн, ЭБНийгэмлэг 1, Аймгийн аварга эмч 1, Аймгийн Хүндэт тэмдэг 1, АЗДЖуух бичиг -9, АЗДББичиг 13, ЭМГазрын даргын нэрэмжит шагнал 2, БУрт сумын ЗДББичиг 5, байгууллагын шагналаар 25 хүн, ҮЭХорооны шагналаар 8 хүн, МТХолбооны шагнал 2, Оны шилдэг 3, өвлийн өвгөний бэлэг 15 нийт 168 ахмад болон ажилтныг тус тус шагнаж урамшууллаа. Мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж ажилласан 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1 сар хугацаатайгаар 10-15%-иар ур чадварын нэмэгдэлийг тооцон 15585471 мян.төгрөг олгосон.

Ажиллагсдыг идэвхжүүлэх, өөр хооронд баг болгож өрсөлдүүлэх, ажлын идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн аян уралдаан тэмцээнийг зохион байгуулж Тэргүүн байр эзэлсэн баг хамт олныг гадаад дотоодод аялуулж ирсэн Эмнэлгийн ажилчдын баяраар ҮЭХорооны дэмжлэгтэйгээр 42 ажилтныг Хэнтий аймгийн Дадал, Гурван нуурын амралтанд амрууллаа. Ажилтан албан хаагчийн гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох тэднийг дэмжин ажиллахад анхаарч "Аз жаргалтай гэр бүл өдөрлөг"-ийг амжилттай зохион байгуулж 12 гэр бүлийг хүүхдүүдийн хамт хамруулж дурсгалын зүйл олгож 1 өдрийг хамт өнгөрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч ажилласан. Жилээс жил ирэх тусам шагнал урамшууллын тоо нэмэгдэж, шагнал хэт хавтгайрах эрсдэл харин дагуулж байна.



#### Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

Ажиллагсдын нийгмийн асуудалд анхаарч БНСУлсад ажиллах хүсэлтэй 16 хүнд албан бичгийг хийж өгснөөс 2017 онд 10 хүнийг 1-2 сарын чөлөө олгож дэмжлэг үзүүллээ. Орон гэр нь байгалийн гамшигт нэрвэгдсэн 1 ажилтанд хамт олны дунд хандивын аяныг өрнүүлж 1328,0 мян төгрөгийг олгож сэтгэл санааны дэмжлэг үзүүллээ.

Батлагдсан төсвийн дагуу 286 хүнд сар бүр хоолны хөнгөлөлт /сард 22000 төгөрг/ үзүүлж байгаа ба жилийн эцсийн байдлаар 62,804,000 төгрөг олгожээ.

Ажлын хүнд нөхцөлд ажиллаж буй 17 ажиллагсдад хор саармагжуулах зорилгоор өдөр бүр 4л сүүг олгож нийт 1609310 төгрөгийг зарцуулсан.

#### Ажиллаж орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд:

Тасаг нэгж бүр алжаал тайлах өрөө, хувцас солих өрөөтэй ба /Лаб, СЗЭ, Амбулаториос бусад/ 2017 онд аймаг орон нутгийн дэмжлэгтэйгээр ЯТ,МЭЭ-ний ажилчдын орчин нөхцөл сайжруулсан ба зарим тасаг нэгжүүдэд байгууллагаас хэсэгчилсэн урсгал засварыг хийж ээлтэй орчныг бүрдүүлсэн.

#### Ерөнхий дүгнэлт:

Хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс нарийн мэргэжлийн эмч нарын ажлын ачаалал нэмэгдэж эмчилгээний стандартад эрсдэл гарах нөхцөл бүрдсэн байна.

Тус нэгдсэн эмнэлэгт мэргэшсэн туршлагатай эмч мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулж байна. Тус нэгдсэн эмнэлэг 297 ажиллагсадтай батлагдсан төсвөөс 9 орон тоо илүү ажиллуулж байна. Үүнээс үндсэн мэргэжил эзэмшсэн их эмч 95%, төрөлжсөн мэргэжил эзэмшсэн их эмчийн хангалт 42% байна. Нийт ажиллагсдын 90% нь мэргэшсэн туршлагатай ажиллагсад ажиллаж байна.

Хүний нөөцийн төлөвлөлтийг аймгийн хүн ам, нийт өвчлөл, үйлчлүүлэгсдийн хүлээгдэл чирэгдэл, батлагдсан стандарттай харьцуулан 5 жилээр хийж үндсэн мэргэжил эзэмших сургалтын хуваарийг оны өмнө /төсөв хэлэлцэх/ ЭМГазарт хүргүүлдэг боловч тус нэгдсэн эмнэлгийн нэн шаардлагатай хуваарь ирэхгүй /Жнь 2016,2017 онд ЭБЭ-ийн хуваарь ирээгүй/ сумын ЭМТөвөөс явуулдаг зэрэг хүндрэлтэй байна. Жич: Сургалтын хуваарь, нэн шаардлагатай орон тооны санал хүсэлтийг өгсөн болно.

Иймээс 2017 онд резиденс сургалтанд үргэлжлүүлэн 3 их эмч сурч, 11-р сард 2 их эмч төгссөн, 2017-2018 оны хичээлийн жилд үндсэн мэргэжилд 4 их эмч, төрөлжсөн мэргэжил 3 их эмч, сувилагч тусгай мэргэжилтэн 10 хүнийг тус тус сургаж байгаа ба Хүний нөөцийн сургалтыг жил бүр оновчтой зөв төлөвлөж тасралтгүй сургасны үр дүнд нэн шаардлагатай эмч мэргэжилтнүүд хангагдаж дээд шатлалд хийгддэг оношлогоо эмчилгээг орон нутагтаа нэвтрүүлж мэс заслын хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлсэн. Мөн 3 дахь шатлалд хийгддэг оношлогоо шинжилгээг орон нутагт хийж байгаа зэрэг давуу талтай.

Жнь: Эрүүл мэндийн гол үзүүлэлт болж буй хүүхэд нярайн эндэгдлийг бууруулахын тулд хүүхдийн эмч 5, нярайн эмч 2 бэлтгэгдэн ажиллаж байна. Эх нярайн тусламжийг сайжруулахын тулд Эх барих эмэгтэйчүүдийн эмчийг 2017 онд 1 их эмчийг бэлтгэж байна. Дотрын өвчин эмгэгийн эмчийг 1 их эмчийг мөн 2017 онд сургаж орон тоог нэмэгдүүлсэн зэрэг давуу талтай.



Гэвч ажиллагсдын 255 эмэгтэйчүүд үүнээс ихэнх 50% залуужсан тул нөхөн үржихүйн асуудал төрөх, хүүхэд асрах зэрэг тохиолдолд хүний нөөцийн хүрэлцээ дутмаг хүндрэл үүсэж байна.

**Ажиллагсдын ил тод сонгон шалгаруулалт:**

Эмнэлгийн эмч, сувилагч нарын төгсөлт сүүлийн үед нэмэгдэж байгаа боловч ЭМТухай хуулийн 25 дугаар зүйлийн дагуу мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эмч, сувилагч, мэргэжилтнүүд ажиллах шаардлагатай тул хүний нөөцийн бүрдүүлэлтийг ажил горилогчийн өргөдлийг үндэслэн ярилцлага хийсний үндсэн дээр хүний оронд томилон ажиллуулдаг.

Харин цаашид тухайн хүнийг ажиллах хугацаанд зан чанар, ажлын идэвхи зэргийг харгалзан сул орон тоондоо дотроосоо нөөцөө бүрдүүлж байна.

ДАРГА



Д.ОЮУНГЭРЭЛ

- 3.6.8 Нэгдсэн эмнэлэгийн чанарын албанаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, аудитын явцад албан хаагчидтай хийсэн уулзалт ярилцлага, судалгаанд үндэслэн дүгнэсэн.
- 3.6.9 Сувилагчийн илүү цагийн нэмэгдлийг тухай бүр олгодоггүй, сар бүр олгож байгаа хоол унааны хөнгөлөлт нь өдрийн цайны цаг зориулагдах хэм хэмжээ бөгөөд шөний ээлжинд ажиллаж буй сувилагчдад хоол өгдөггүйтэй холбогдуулан гарсан дүгнэлт болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

С.АРИУНБАЯР  
Б.АРИУНЗУЛ

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
М.НАРАНТУЯА  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ДАВАА

